## БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2023 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Стратеги төлөвлөгөөний зорилго 1. Монгол Улсын Их хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх | | | | | | | |
| 1 | Зорилт 1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах | - | Гэрээний хэрэгжилтийн хувь | 90% | 92.5% | Эрүүл мэндийн сайд_аймгийн засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт хагас жилийн байдлаар 70 %тай гарсан. Бүтэн жилийн байдлаар 1 сарын 6-нд явуулна. | 90% |
| 1.1 | Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг орон нутаг салбарын хэмжээнд зохион байгуулах | - | Гэрээний хэрэгжилтийн хувь, шалгуур үзүүлэлтээр | 85% | 90% | | |
| 1.2 | Эрүүл мэндийн сайд, аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлтийг хагас бүтэн жилээр гаргаж, АЗДТГ болон ЭМЯ-нд тайлагнах | - | Гэрээний хэрэгжилтийн хувь, шалгуур үзүүлэлтээр | 85% | 90% | | |
| Стратегийн зорилго 2. Хүн амыг амьдралын хэв маягаас үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл таатай орчинд ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд салбар дундын хамтын ажиллагааг хангах | | | | | | | |
| 2.1 | Зорилт 1. Хүн амыг амьдралын хэв маягаас үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл таатай орчинд ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд салбар дундын хамтын ажиллагааг хангах Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.2.1, | | Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо | - | 4 | 100% | 100% |
| | | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж хувь | - | 90%-иас доошгүй | 100% | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2.1.6 | | | | | | |
| 2.1.1 | “Эрүүл чийрэг эр хүн”, “Эрүүл идэвхтэй амьдрал” арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллана | 2,5 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 90%-иас доошгүй | “Эрчүүдийн эрүүл мэндийг хамгаалахад эмэгтэйчүүдийн оролцоо” сэдэвт хэлэлцүүлгийг эрүүл мэндийн газарт зохион байгуулж, аймгийн төвийн төрийн болон төрийн бус байгууллагын 60 албан хаагчид Халдварт болон халдварт бус өвчлөл, эрүүл зөв хооллолтын ач холбогдол, илүүдэл жин, таргалалтаас сэргийлэх арга, сүрьеэ, БЗДХ/ДОХ-ын өвчлөл, биеийн жингийн индексээ тодорхойлох арга, Идэвхтэй хөдөлгөөн хийж, жингээ эрүүлээр хасах сэдвээр сургалт явуулж, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Эрүүл зөв хооллолт, дасгал хөдөлгөөний ач холбогдлын чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагууд, мөн хилийн цэргийн 0285 дугаар ангийн бие бүрэлдэхүүн болон 5 застав, зэвсэгт хүчний 340 дүгээр анги, хилийн цэргийн 0165 дугаар ангийн бие бүрэлдэхүүнд нийт 350 албан хаагчид ажлын байрны сургалт явуулж, түмэн дасгалыг сурталчилсан. Залуучуудын дунд урьдчилан сэргийлэх аюулгүй байдал ХДХВ/ДОХ болон бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр тогтмол ухуулга сурталчилгаа хийгддэг өсвөр үеийн залууст ээлттэй кабинет, НЭ ийн БЗДХ-ын кабинетийн дэргэдэх Сайн дурын зөвлөгөө өгөх кабинетээр дунджаар 1250 хүнд зөвлөгөө өгч ажилласан. Аймгийн нэгдсэн эмнэлэгт дурангийн хагалгааг нэвтрүүлж, 2023 оны 08 сарын байдлаар 20 хүн хагалгаа хийж тусламж үйлчилгээ үзүүлсэн Архи, тамхины зохисгүй хэрэглээ, электрон тамхины хор уршиг, нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр ХИС-ийн Баян-Өлгий аймаг дах салбар сургууль, МСҮТ-ийн нийт 80 оюутанд сургалт явуулсан. Мөн 5, 11 дүгээр багийг иргэдэд хорт зуршил, халдварт бус | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өвчнөөс сэргийлэх, хавдраас хамгаалах, эрт илрүүлгийн ач холбогдлын талаар сургалт явуулсан. ЕБСургуулийн ахлах ангийн сурагчдад “Зөв зохистой хооллолт”, “Хорт зуршлаас татгалзах”, “Чихэрлэг зүйлсийн хэрэглээг хязгаарлах” зэрэг сэдэвт сургалтыг зохион байгуулав. Нийт 121 сурагч хамрагдсан. Сумын албан байгууллагуудын дунд дасгал хөдөлгөөнийг дэмжих зорилгоор гар бөмөг, сагсан бөмбөгийн тэмцээн зохион байгуулж явуулав. Энэ үйл ажиллагаанд сумын 4 цэцэрлэг, 3 сургууль, Соёлын төв, гал түймэр унтраах 71-р анги, ЭМТ-ийн 62 албан хаагчид оролцсон. Цэнгэл сумын 2-р сургуулийн ахлах ангийн хөвгүүдэд электрон тамхины хор уршгийн талаар сургалт хийж мэдээлэл өгч 45 сурагч хамрагдсан. Толбо сум Сургуулийн эмч сургуулийн нийгмийн ажилтантай хамтран өсвөр насны хөвгүүдэд сургалт сурталчилгааг 4 удаа зохион байгуулж, 90 хүнийг хамруулсан. | |
| 2.1.2 | “Хавдрын эсрэг” арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллана | 2,5 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 90%-иас доошгүй | Хавдрын тасагт шинээр 16 ор нээгдэж, үйл ажиллагаагаа явуулж байна. Эхний 11 сарын байдлаар давхардсан тоогоор 163 хүн, тасагт хэвтэж хөнгөвчлөх тусламж үйлчилгээ авсан 206 хүн, бай эмчилгээг 2022 оны 11 сараас нэвтрүүлж, орчин үеийн шинэ эм бэлдмэлээр хөнгөвчлөх тусламж үйлчилгээг явуулж байна. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагууд дараах хоёр төрлийн хавдрын эрт илрүүлэг үзлэгийг эмэгтэйчүүдэд хийж байна. 2023 оны 11 сарын байдлаар хөхний өмөнгийн эрт илрүүлэгт хамрагдах ёстой 23753 эмэгтэй байгаагаас 14275 эмэгтэй хамрагдаж, үүнээс үрэвсэлтэй 127 эмэгтэй үрэвслээр оношлогдож эмчилгээнд хамрагдсан бол хавдрын урьдлын эмчилгээнд 47 хүн хамрагдсан. Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт нийт 5721 эмэгтэй байгаагаас 2796 буюу 48.8 хувь нь хамрагдсан ба үзлэг шинжилгээгээр 110 эмэгтэй үрэвсэлтэй илэрч 96 хүн эмчилгээнд хамрагдсан бол хавдрын урьдлаар 7 эмэгтэй оношлогдож эмчилгээнд хамрагдаж, 6 эмэгтэй LEEP эмчилгээнд орсон.. Эрт илрүүлгийн ач | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбогдол, хавдраас урьдчилан сэргийлэх, архи тамхины хэрэглээ, электрон тамхины хор уршгийн талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 3 удаа ард иргэдэд чиглэсэн мэдээлэл хүргүүлсэн. “Хавдрын эсрэг” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах зорилгоор 2 дугаар сарын 04-ний өдөр хавдартай тэмцэх дэлхийн өдөртэй холбоотой өдөрлөгийг Нэгдсэн эмнэлгийн хавдрыг кабинеттай хамтран зохион байгуулж, 90-ээд хүнд сурталчилгаа явуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрт илрүүлэг үзлэг, хавдраас сэргийлэх арга зам, аймгийн хэмжээнд байгаа өвчлөл, нас баралтын статистик тооны чиглэлээр ард иргэдэд чиглэсэн мэдээлэл хүргүүлсэн. Архи тамхины хэрэглээ ба хорт хавдар, электрон тамхины хэрэглээ, эрүүл зөв амьдрах, халдварт бус өвчний эрсдэлээс ангижирч сурах, тамхинаас гарах тухай сэдэл төрүүлэх, дам тамхидлтаас сэргийлж сурах сэдвүүдээр хилийн цэргийн 0285 дугаар ангийн бие бүрэлдэхүүн, 5 заставын 150 хүн, Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн 150 гаруй ажилтан албан хаагчдад сургалт явуулж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Хорт зуршил, халдварт бус өвчнөөс сэргийлэх, хавдраас хамгаалах, эрт илрүүлгийн ач холбогдлын талаар сургалтад 5, 11 дүгээр багийг иргэд, МСҮТ, ХИС-ийн Баян-Өлгий аймаг дах салбар сургууль 140 оюутныг хамруулсан. Тамхигүй дэлхийн өдрийг угтаж төв талбайд ард иргэдэд чиглэсэн сурталчилгаа явуулж, 100 хүнд тамхины хор уршгийн талаар санамж хуудас, гарын авлага тараасан. Увс аймагт зохион байгуулагдсан баруун бүсийн удирдах ажилтны зөвлөгөөнд ЗДТГ-ын НБХ, ЭМГ, НЭ-ийн дарга, мэргэжилтнүүд оролцож, аймгийн хавдрын тусламж үйлчилгээний өнөөгийн байдал сэдэвт илтгэл тавьсан. Эрт илрүүлэг үзлэгийн ач холбогдол, халдварт бус өвчнөөс сэргийлэх чиглэлээр орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр мэдээлэл хүргэсэн. Эрт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | илрүүлгийг эрчимжүүлэх чиглэлээр Жаншарапат, Нурлы, Аймгийн нэгдсэн эмнэлгийн Дэмжих төвийн эмч нартай уулзаж 1 удаа хэлэлцүүлэг, 1 удаа ажлын байранд нь зөвлөн туслахаар ажилласан. Өндөр эрсдэлтэй жирэмсэнг эрт илрүүлэг, жирэмсний хяналтыг сайжруулах зорилгоор Өрхийн эрүүл мэндийн төвийн их эмч, сувилагч нарт “Өндөр эрсдэлийг илрүүлэг” сэдэвт сургалтыг Уг ЭХЭМҮТөвийн эх барих эмэгтэйчүүдийн эмч, ЭМГазрын Эх барих эмэгтэйчүүд, нярайн асуудал хариуцсан мэргэжилтэн нар зохион байгуулан, мэдээлэл арга зүйгээр ханган ажиллаа. Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж баруун бүсийн сургалтад 2 эх барих эмэгтэйчүүдийн эмч, 2 нярайн эмч, 3нярайн сувилагч 1 эх баригч хамрагдсан. | |
| 2.1.3 | “Харшлаас сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллана | 1,5 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 90%-иас доошгүй | Аймгийн Нэгдсэн эмнэлэгийн арьс харшлын тасаг нь 2 их эмч ,6 сувилагч, 4 асрагчтайгаар ажиллаж байна. Үүнээс арьс судлалаар 2 их эмч 2018, 2020 онуудад мэргэжсэн. их эмчийн мэргэжсэн 2 сувилагч 3 сарын сургалтанд хамрагдсан байна. ЕБС-ийн эрүүл мэндийн хичээлийн багш, сурагч нарт “Өсвөр үеийн 7 хоног” сэдэвт өдөрлөгт харшлын өвчнөөс сэргийлэх, эрсдлийг бууруулах сэдвээр сургалт зохион явуулсан.Уг сургалтад 15 эрүүл мэндийн багш, 300 сурагч хамрагдсан. 2023 оны 11-р сарын байдлаар амбулаториор үйлчлүүлж байгаа ард иргэдэд “Харшлын өвчнөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр амбулаториор харшлын шалтгаантай хандсан 2871 хүнд харшлаас сэргийлэх зөвлөгөө өгч, 11 төрлийн 665 ширхэг санамж хуудас тараасан. Харшлын 7 хоногийн аяны хугацаанд “Харшлыг хашраая” уриан дор аймгийн Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн арьс харшлын тасаг хамтарч өдөрлөг зохион явуулж, иргэдэд 5 төрлийн 250 ширхэг гарын авлага тарааж, харшлын эрсдэлт хүчин зүйлийн талаар сурталчилгаа явуулсан. Харшлаас сэргийлэх эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аймгийн төвийн 4 өрхийн ЭМТ,12 сум, 1 тосгоны ЭМТ-үүд сургууль цэцэрлэг, ард иргэд, эмч, эмнэлгийн мэргэжилтэнүүдэд сургалт зохион байгуулан ажиллаж байна. Сургууль, цэцэрлэгт 15, ард иргэдэд 27, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд 8 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулан ажиллаж байна. Сургууль цэцэрлэгийн 863 хүүхэд, 1814 ард иргэд, 92 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд танхимын сургалтад хамруулж, иргэдэд 6 төрлийн 1200 ширхэг гарын авлага тарааж, харшлын эрсдэлт хүчин зүйлийн талаар сурталчилгаа явуулсан. Өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч нарыг харшлын өвчний цогц менежментийн танхимын сургалтыг Жансая болон Шипагер өрхийн эрүүл мэндийн төвүүдэд сургалт явуулсан . Уг сургалтад 15 эмч эмнэлгийн ажилтнуудыг хамруулсан. Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс 7 хоногт нэг удаа Өлгий сумын 4 өрхийн эрүүл мэндийн төв, 12 сум, 1 тосгоны ЭМТ-үүдэд Zoom-ээр цахим хурал хийж хэвшсэн байна. Тус цахим уулзалтаар Арьс харшлын тасгийн эрхлэгч, их эмч С.Берикгүл ӨЭМ-үүдийн дарга болон нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудад манай аймагт сүүлийн үед их тохиолдож байгаа өвчлөлүүдийн талаар мэдээлэл өгч, сургалт явуулж, арга зүйгээр хангасан. Уг сургалтад 16 Эрүүл мэндийн төвийн дарга, 16 нийгмийн эрүүл мэндийн ажилтан хамрагдлаа. Цаашид Нийгмийн эрүүл мэндийн хэлтэстэй хамтран долоо хоног бүр өрх, сум тус бүртэй тулж ажиллан, салбар дундын уулзалт, хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллахаар төлөвлөж байна. | |
| 2.1.4 | “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллана | 3,5 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 90%-иас доошгүй | “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан АЗДТГ-ын Нийгэм бодлогын хэлтэст 1%-ийг хүргүүлсэн. Хэрэгжилтийн хувь 90% | 90% |
| 2.2 | Зорилт 2. Халдварт болон халдварт бус өвчлөлийг эрт илрүүлж, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх | | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалт | 39.5 | 42%-иас доошгүй | Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | “Алсын харaa-2050” МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2.2.1, 2.2.2,2.2.5, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.2.2, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагаа хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.1 | | ын дундаж хувь | | | хамруулах үйл ажиллагааны хэрэгжилтийг хангахаар Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмч нарын баг нь Глобал сангийн санхүүжилтээр Улаанхус суманд үйл ажиллагаа явуулдаг Зэвсэгт хүчний 116-р салбарын 60 албан хаагч, Улаан байшинт боомтын иргэд, албан хаагчид, хилийн цэргийн 0285 дугаар ангийн албан хаагч нийт 38 хүн буюу нийт 98 хүнийг явуулын аргаар эрт илрүүлэг үзлэг шинжилгээнд хамруулж, сүрьеэгийн нэг шинэ тохиолдлыг илрүүлсэн. Глобал сангийн санхүүжилтээр 2023 оны 05 дугаар сар хүртэл сумдын эрүүл мэндийн төвөөс 270 хүний 540 цэрний сорьцын нэгдсэн эмнэлгийн сүрьеэгийн лабораторид тээвэрлэж, шинжилгээнд хамруулсан. Улсын хэмжээнд Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаалын дагуу явагдаж байгаа эрт илрүүлэг манай аймагт 33.6 хувьтай байгаа. Уг үзлэгийг 18-аас дээш насныханыг Аймгийн нэгдсэн эмнэлгийн дэмжих төв, Нурлы мэдрэл уламжлалтын хувийн эмнэлэг, Жаншарапат дотрын хувийн эмнэлгүүд хийж гүйцэтгэж байгаа. 0-17 насны хүүхдүүдийн үзлэг нийт 57.6 хувьтай ба үүнээс 803 хүүхэд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтад орсон, лавлагаа шатлал руу 374 хүүхдийг илгээсэн. Харин 18-аас дээш насны иргэдийн эрт илрүүлэг 16.4 хувьтай ба үүнээс анхан шатны ЭМБ-ын хяналтанд шилжүүлсэн 1997 хүн, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг рүү 250 хүнийг шилжүүлэн ажиллаж байна. Элэг бүтэн Монгол” арга хэмжээний (2022-2025) ЭМС-ын 2022 оны А/577 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний биелэлтийг 4 зорилтын хүрээнд 2023 оны хагас жилийн байдлаар гаргасан. 2023 оны байдлаар “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд үзлэг шинжилгээнд 15-дээш насны 9612 хүн хамрагдаж, хамралт 15%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. | |
| | | | Эрт илрүүлэг, | 72.7% | 75%-иас доошгүй | 2023 оны эхний 5 сарын байдлаар эрт илрүүлэг үзлэгт 2026 иргэн хамрагдсан. Үүнээс элэгний | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | багцын болон урьдчилан сэргийлэх үзлэгээр илрүүлсэн өвчлөлийг эмчлэн эрүүлжүүлсэн хувь | | | В вирус шинээр илэрсэн 26, элэгний С вирус 9, чихрийн шижин өвчин шинээр оношлогдсон 9, бамбайн дутагдал шинээр оношлогдсон 3, элэгний архаг үрэвсэл сэдрэлтэй 8, хөхний фиброз, уйланхай 18, бамбайн зангилаа нэг ба олон тооны 306, түрүү булчирхайн томрол 5, ходоодны хавдар 1, ходоодны хавдрын урьдал үе илэрсэн 1, умайн хүзүүний хавдрын урьдал 1, цөсний чулуутай шинээр оношлогдсон 20, бөөр, шээсний замын өөрчлөлттэй 486, амьсгалын замын өөрчлөлттэй 252, зүрх судасны өөрчлөлтэй 22, артерийн гипертензи 48, бодисын солилцооны өөрчлөлттэй 213 тус тус оношлогдож, нарийн мэргэжлийн эмчийн хяналтад орсон. Нийт хамрагдалт 37.8. Үүнээс 18-аас доош насны хамрагдалт 54,7, 18-аас дээш насны хүмүүсийн хамрагдалт 14.8% байна. | |
| | | | Хорт хавдрын үе шатанд тохирсон эмчилгээ хийлгэсэн хүний хувь | 100 | 90-ээс доошгүй | Шинээр 16 ортой хавдрын тасаг нээгдэж хавдартай өвчтнүүдэд тусламж үйлчилгээг үзүүлж байна. Манай аймаг хими эмчилгээг 2013 оноос, бай эмчилгээг 2022 оны 11 сараас нэвтрүүлж, орчин үеийн шинэ эм бэлдмэлээр хөнгөвчлөх тусламж үйлчилгээг явуулж байна. Бай эмчилгээг тариа болон уухаар 2 төрлөөр хийгдэж эхэлсэн. 167 /давхардсан тоогоор/ хими эмчилгээнд орсон. | 100% |
| | | | Зонхилон тохиолдох БЗДХ-ыг хяналтад авч эмчлэн эрүүлжүүлсэн хувь | 100 | 100 | 2023 оны 12 дугаар сарын байдлаар БЗДХ-ын зонхилон тохиолдох 58 шинэ тохиолдол бүртгэгдсэн. Тэмбүү 5, заг хүйтэн 42, трихомониаз 9, ХДХВ/ДОХ-ын 2 тохиолдол бүртгэгдсэн ба бүгд эмчийн хяналтад орж эмчилгээ хийлгэсэн. Одоогийн байдлаар ХДХВ/ДОХ-ын 2 тохиолдол эмчийн хяналтад байгаа. | 100% |
| | | | Тэмбүүгийн хавьтал илрүүлгийн хувь | 70.9 | 71 | 2023 онд шинээр оношлогдсон тэмбүүгийн 5 тохиолдлын яригдсан 10 ойрын хавьтлыг БЗДХ илрүүлэх шинжилгээнд хамруулж хавьтал судлалын судалгаа хийгдсэн болно. | 100% |
| | | | Сүрьеэгийн үзлэгт хамрагдсан зорилтот | 85.9 | 87 | Глобаль сангийн санхүүжилтээр сумын эрүүл мэндийн төвөөс 203 хүний 406 цэрний сорьцыг тээвэрлэж, нян судлалын шинжилгээнд хамруулсан. 2021-2022 онд ажлын байрнаас | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бүлгийн иргэдийн хувь | | | сүрьеэгийн шинэ тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотой Хилийн цэргийн 0285 дугаар ангийн 250 албан хаагч, Улаанхус суманд үйл ажиллагаа явуулдаг хилийн цэргийн ангийн 60 албан хаагч, Жаннур ТББ 40 хүүхэд, ажилтан, 2-12 жилийн сургуулийн 200 сурагч, 40 иргэн цээжний гэрлийн шинжилгээ, асуумж судалгааны арга, цэрний нян судлалын шинжилгээний аргаар идэвхтэй илрүүлэг үзлэгт хамруулсан. | |
| | | | Сүрьеэгийн эмчилгээний чанарын хувь | 96.7 | 95.%-иас доошгүй | 2023 оны 12 дугаар сарын байдлаар сүрьеэгийн шинэ тохиолдол 23 илэрч эмчилгээнд хамрагдсан байна. Мөн далд халдварын эмчилгээнд 29 хүн хамруулан ажиллаж байна. | 100% |
| | | | Товлолт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь | 99.5 | 98 %-иас доошгүй | 2023 оны 12 дугаар сарын байдлаар БЗДХ-ын зонхилон тохиолдох 58 шинэ тохиолдол бүртгэгдсэн. Тэмбүү 5, заг хүйтэн 42, трихомониаз 9, ХДХВ/ДОХ-ын 2 тохиолдол бүртгэгдсэн ба бүгд эмчийн хяналтад орж эмчилгээ хийлгэсэн. Одоогийн байдлаар ХДХВ/ДОХ-ын 2 тохиолдол эмчийн хяналтад байгаа. | 100% |
| 2.2.1 | Хүн амын нас, хүйс, эрсдэлт хүчин зүйлд тулгуурласан багцын эрт илрүүлэг, хариу арга хэмжээг чанартай, хүртээмжтэй, тасралтгүй зохион байгуулна. | | Эрт илрүүлгийн хамрагдалтын дундаж хувь | 45.8 | 55 | 2023 онд шинээр оношлогдсон тэмбүүгийн 5 тохиолдлын яригдсан 10 ойрын хавьтлыг БЗДХ илрүүлэх шинжилгээнд хамруулж хавьтал судлалын судалгаа хийгдсэн болно. | 100% |
| | | | Багцын үзлэгийн хамрагдалтын хувь | 7.3 | 45 | Улсын хэмжээнд Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаалын дагуу явагдаж байгаа эрт илрүүлэг манай аймагт 33.6 хувьтай байгаа. Уг үзлэгийг 18-аас дээш насны иргэдийг Аймгийн нэгдсэн эмнэлгийн дэмжих төв, Нурлы Жаншарапат дотрын хувийн эмнэлгүүд хийж гүйцэтгэж байгаа. 0-17 насны хүүхдүүдийн үзлэг нийт 57.6 хувьтай ба үүнээс 803 хүүхэд анхан шатны эрүүл мэндийн байгууллагын хяналтад орсон, лавлагаа шатлал руу 374 хүүхдийг илгээсэн. Харин 18-аас дээш насны иргэдийн эрт илрүүлэг 16.4 хувьтай ба үүнээс анхан шатны ЭМБ-ын хяналтанд шилжүүлсэн 1997 хүн, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг рүү 250 хүнийг шилжүүлэн | |
| | | | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтын хувь | 39.8 | 40 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллаж байна. | |
| | | | Нийт 3 үзлэгээр илрүүлсэн өвчлөлийг эмчлэн эрүүлжүүлсэн хувь | 100 | Эмчлэн эрүүлжүүлбэл зохих тохиолдол бүрийг 100% | 100% | |
| 2.2.2 | 30-аас дээш насны иргэдийг 7 төрлийн хорт хавдрын эрт илрүүлгийн үзлэгт хамруулж илэрсэн хавдрын үе шатанд тохирсон эмчилгээ хийнэ. | | Хавдрын эрт илрүүлэгт хамрагдалтын хувь | 43.2 | 55 | Хөхний өмөнгийн эрт илрүүлэгт хамрагдах ёстой 23753 эмэгтэй байгаагаас 14474 эмэгтэй хамрагдаж, хамрагдалт 60.8%. Үүнээс үрэвсэлтэй 127 эмэгтэй үрэвслээр оношлогдож эмчилгээнд хамрагдсан бол хавдрын урьдлын эмчилгээнд 47 хүн хамрагдлаа. Умайн хүзүүний эрт илрүүлэг үзлэгт нийт 5721 эмэгтэй байгаагаас 2651 буюу 46.3 хувь нь хамрагдсан ба үзлэг шинжилгээгээр 88 эмэгтэй үрэвсэлтэй илэрч эмчилгээнд хамрагдсан бол хавдрын урьдлаар 2 эмэгтэй оношлогдож эмчилгээнд хамрагдсан бол, 6 эмэгтэй LEEP эмчилгээнд орсон. | 100% |
| | | | Хорт хавдрын үе шатанд тохирсон эмчилгээ хийлгэсэн хүний хувь | 100 | 90-ээс доошгүй | Шинээр 16 ортой хавдрын тасаг нээгдэж хавдартай өвчтнүүдэд тусламж үйлчилгээг үзүүлж байна. Манай аймаг хими эмчилгээг 2013 оноос, бай эмчилгээг 2022 оны 11 сараас нэвтрүүлж, орчин үеийн шинэ эм бэлдмэлээр хөнгөвчлөх тусламж үйлчилгээг явуулж байна. Бай эмчилгээг тариа болон уух гэсэн 2 төрлөөр хийгдэж байна. | 100% |
| 2.2.3 | БЗДХ-ын илрүүлэх үзлэг, аян зохион байгуулан илрүүлгийг нэмэгдүүлж, илэрсэн өвчлөлийг хяналтад авч, эмчлэн эрүүлжүүлнэ. | | Зонхилон тохиолдох БЗДХ-ыг хяналтад авч эмчлэн эрүүлжүүлсэн хувь | 100 | 100 | АНЭ-ийн БЗДХ-ын кабинетын амбулаторийн үзлэгт 11894 иргэн хамрагдсанаас анх хандсан нь 6247, давтан 3061, урьдчилан сэргийлэх үзлэг 2586 байна.<br>2023 оны 12 дугаар сарын байдлаар эрт илрүүлэг үзлэгийн ХДХВ/ДОХ, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 10232 хүн хамрагдаж, эерэг тохиолдол илрээгүй.<br>2023 оны 12 дугаар сарын байдлаар тэмбүү 5, заг хүйтэн 42, трихомониаз 9, ХДХВ/ДОХ-ын 2 тохиолдол бүртгэгдэж, эмчийн хяналтад орсон.<br>2023 онд нэгдүгээр ээлжийн цэрэг татлагаар 550, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагаар 566 цэргийн насны залуучууд ХДХВ/ДОХ, тэмбүү | 100% |
| | | | Тэмбүүгийн хавьтал илрүүлгийн хувь | 70.9 | 71.0 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | илрүүлэх хурдавчилсан шинжилгээнд хамрагдаж, 1 тэмбүү өвчний эерэг тохиолдол батлагдаж эмчийн хяналтад орсон болно.<br>12 дугаар сарын 1-ний өдрийг дэлхий нийтээрээ ХДХВ/ДОХ-ын асуудалд анхаарал хандуулах өдөр болгон тэмдэглэн өнгөрөөдөг. Энэ жил “Олон нийтийн манлайллыг дэмжье" уриан дор дэлхий нийтээр ХДХВ/ДОХ-ын асуудалд анхаарал хандуулж байна.Тус өдрийн хүрээнд ХДХВ/ДОХ-той тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, халдвараас урьдчилан сэргийлэх, хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор нөлөөллийн ажлыг Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн БЗДХ-ын кабинет, Эмэгтэйчүүдийн Арулар ТББ, Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран Ерөнхий Боловсролын 1 дүгээр сургуулийн 11, 12-р ангийн сурагчдын дунд ХДХВ/ДОХ-ын асуудалд анхаарал хандуулах өдрийг олон нийтэд таниулан сурталчлах, мэдлэг олгох сургалт явуулж, АХА тэмцээн зохион байгуулан 7 сурагчийг шагнан урамшуулж, цаашдын сурлагаас нь амжилт хүсэж ,тус өдрийг тэмдэглэн өнгөрүүлсэн. Оюутны эрүүл мэндийг дэмжих сарын хүрээнд ХӨСҮТ-ийн БЗДХ, ХДХВ/ДОХ тандалт, судалгааны албаны бэлдсэн 4 төрлийн видео шторкийг Дербес телевизийн пэйж хуудсанд байршуулан ард иргэдэд түгээн ажилласан ба хандалтын тоо 6120 хүн, 35 хүн хуваалцсан байна. | |
| 2.2.4 | Сүрьеэ өвчний илрүүлэх зорилтот бүлэгт чиглэсэн үзлэгийг зохион байгуулан илрүүлгийг нэмэгдүүлж, илэрсэн өвчлөлийг эмчлэн эрүүлжүүлнэ. | | Үзлэгт хамрагдсан зорилтот бүлгийн иргэдийн хувь | 85.9 | 80%-иас доошгүй | 2023 оны 12 дугаар сарын байдлаар сүрьеэгийн эрт илрүүлэг үзлэгт 10232 иргэн хамрагдаж, сүрьеэгийн сэжигтэй тохиолдол илрээгүй.<br>АНЭ-ийн сүрьеэгийн амбулаторийн үзлэгт 4331 иргэн хамрагдсан ба үүнээс анх 624, давтан 276, урьдчилан сэргийлэх 3386, идэвхтэй хяналт 45 байна.<br>2023 оны 12 дугаар сарын байдлаар сүрьеэгийн шинэ тохиолдол 23 илэрч эмчилгээнд хамрагдаж байна.<br>Глобаль сангийн санхүүжилтээр сумын эрүүл мэндийн төвүүдээс эрсдэлт бүлгийн хүн амыг | 100% |
| | | | Далд хэлбэрийн сүрьеэ илрүүлэх арга хэмжээний тоо | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Эмчилгээний чанарын хувь | 96.7 | 97%-иас доошгүй | цэрний нян судлалын шинжилгээнд хамруулж байна. Үүнд: 12 сум, 1 тосгоны эрүүл мэндийн төвөөс 203 хүний 406 цэр тээвэрлэгдэж, нян судлалын шинжилгээнд хамрагдсан.<br>Аймгийн төвийн 20 цэцэрлэгийн 380 багш, ажилчид, 30 албан байгууллагын 620 албан хаагч, МСҮТ-ийн 140 оюутан, МУБИС-ийн салбар сургуулийн 70 оюутан, аймгийн төвийн албан байгууллагын 60 эрэгтэй албан хаагч, “Дэлхийн музейн өдөр”-ийг тохиолдуулан явуулсан өдөрлөгт 80 иргэн, дэлхийн “Сүрьеэтэй тэмцэх өдөр”-ийг тохиолдуулан 140 гаруй иргэн, олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан "Аз жаргалтай гэр бүл” өдөрлөгийн хүрээнд 80 хүн, Жаннур ТББ-ын 40 хүүхэд, 2-12 жилийн сургуулийн 260 сурагч, ажилчид нийт 1870 хүнийг хамруулан сүрьеэгээс сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг явуулсан.<br>2023 оны эхний 12 дугаар сарын байдлаар далд халдварын эмчилгээнд 29 хүн хамрагдаж байна.<br>Глобаль сангийн санхүүжилтээр 2021-2022 онд бүртгэгдсэн 70 өвчтөний 350 орчим хавьтлын хүмүүсийг сорьц тээвэрлэлт, цээжний гэрлийн шинжилгээний аргаар хамруулсан.<br>Мөн 2023 оны 12 дугаар сарын байдлаар бүртгэгдсэн 23 шинэ тохиолдолын 45 хавьтлыг үзлэг шинжилгээнд хамруулсан.<br>Монголын Сүрьеэтэй тэмцэх нийгэмлэгийн Баян-Өлгий дэхь салбараас 2023 оны 12 дугаар сарын байдлаар 12 хүнд хоол олгосон бөгөөд нэг хүнд 125000 төгрөгийн буюу нийт 1500000 төгрөг зарцуулсан байна.<br>2023 оны 12 дугаар сарын байдлаар 25 хүнийг хөдөлмөр чадвар алдалтын тэтгэмжид хамруулсан. | |
| 2.2.5 | Товлолт дархлаажуулалтын арга хэмжээг тасралтгүй зохион байгуулж, тарилгат халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ. | | Тухайн жилийн товлолт дархлаажуулалтад хамрагдсан | 99.5 | 99.5%-иас доошгүй | Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолын дагуу 2 нас хүртэлх хүүхдийн вакцины хамралтыг хугацаанд нь хийж, хамралт 11 сарын байдлаар 95.8 хувьтай байна . Вакцин тус бүрээр авч үзвэл БЦЖ, В гепатитийн эсрэг вакцины хамралт 99.8%, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хүүхдийн эзлэх хувь | | | Халдвар саа 95.9%, Тавт 94.6%, Халдварт саагийн эсрэг идэвхгүйжүүлсэн вакцин 95.5%, УГУ 95%, А гепатит 95,1%, ПЭВ 94.7%, Сахуу татран 96.2.<br>Дархлаажуулалтын тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөө гаргаж, бэлэн байдал хангаж ажилласан. 2023 оны 5-р сарын 29-ээс 06 сарын 10-ны хооронд 10 хоног нэмэлт дархлаажуулалтын ЭМС-ын А/180, А/188-р тоот тушаал, Аймгийн Засаг даргын А/273 захирамж, Эрүүл мэндийн газрын А/24, А/25 тушаалаар Улаанбурхан, улаануууд өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 10 сараас 8 насны хүүхдүүдийг нэмэлтээр дархлаажуулах 20500 хүн тун вакциныг татан авч явуулын хэлбэрээр дархлаажуулалтанд хамруулж, үйл ажиллагааг явуулж байна. Одоогийн байдлаар нийт 10 сараас 8 насны 15363 хүүхдийг хамруулсан ба 73%-тай байна. | |
| Стратеги төлөвлөгөөний зорилго 3. Хүн амын дунд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлэн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх | | | | | | | |
| 3.1 | Зорилт 1.Шинэ болон сэргэн тархаж буй халдварт өвчнөөс сэргийлэх, хариу арга хэмжээг зохион байгуулах<br>/Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 1.1.3/ | | Корона вируст халдварын цар тахлаас сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлын төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 97.8 | 98%-иас доошгүй | Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээний (2022-2025) хөтөлбөр нь 2022 оны 10 дугаар сарын 31-онд шинээр батлагдсан бөгөөд 7 зорилт бүхий 32 үйл ажиллагааг төлөвлөж, хагас, бүтэн жилээр тайлан гаргаж ХӨСҮТ-д хүргүүлсэн. Халдварт өвчний тандалт судалгааг харьяа 12 сум, 4 өрх, Нэгдсэн эмнэлэг болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаас нэгтгэж, ХӨСҮТ-д 48 удаа хүргүүлсэн. 2023 оны байдлаар салхинцэцэг 195, улаанэсэргэнэ 11, гар хөл амны өвчин 57, ёлом 5, В гепатит 3, хачигт халдвар 5, коронавируст халдвар 4, цусан суулга 2, сүрьеэ 23, трихомиоз 9, заг хүйтэн 42, тэмбүү 5, ХДХВ 2, нярайн үжил 6 нийтдээ 368 тохиолдол бүртгэгдэж, тохиолдол бүрийн голомтын хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж, тандалт судалгаа хийж ажилласан. Олон хүнийг хамарсан хоолны хордлогот дэгдэлт гараагүй. 2023 онд тарваган тахал өвчний оношилгооны бэлэн байдлыг хангах зорилгоор шаардлагатай байгаа түргэвчилсэн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оношлуурыг авахад санхүүжилт хүсэж шийдвэрлүүлэх талаар ЗӨСТөвийн 2023 оны 07-р сарын 05-ны өдрийн 83 дугаар албан бичгээр Засаг даргад хандаж Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 1 сая төгрөг шийдвэрлэн аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/413 дугаар “ Хөрөнгө зарцуулах тухай” захирамж гаргуулан, Аглаг мед ХХК-аас 30 ширхэг тарваган тахлын түргэвчилсэн оношлуур захиалан авч бэлэн байдлаа хангасан.<br>Мөн аймгийн Эрүүл мэндийн газарт дэмжлэг дэмжлэгтэйгээр тарваган тахлын сэжигтэй дуудлага болон хээрийн шинжилгээний багийн гишүүдийн хээрийн нөхцөлд ашиглах 1.5 сая төгрөгийн өртөг бүхий 1 ширхэг гэр майхан шийдвэрлүүлсэн | |
| | | | Цахим сурталчил гаанд хандсан иргэдийн хувь | - | Хүн амын 30-аас доошгүй | ЭМГ-ын албаны вэб сайтад 2023 онд томуу, томуу, томуу төст өвчин, гэдэсний халдвар, салхинцэцэг, гар, хөл амны өвчин, тарваган тахал, гэдэсний халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар 395 төрлийн гарын авлага байршуулж, бусдад хуваалцах 395, таалагдсан 4345 байна.<br>Олон улсын гэр бүлийн өдөр, Музейн талбайд “Эрүүл мэнд ба сайн сайхан оршихуйг дэмжих" сэдэвт өдөрлөгийн үер халдварт өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Хоолны хордлогоос сэргийлэх, Салхин цэцэг, Улаан бурхан, Гэдэсний халдвараас сэргийлэх талаар мэдээлэл сургалт сурталчилгаа хийж, 210 ширхэг гарын авлага тараасан. Тус сургалтын үр дүнд ард иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилсэн. | 100% |
| | | | Сурталчил гаанд хамрагдалт ын хувь | - | Хүн амын 70-аас доошгүй | Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх аяны хүрээнд хүрээнд 2023.08.16-2023.08.23-ны хүртэлх хугацаанд аймгийн Нэгдсэн Эмнэлэгийн Яаралтай тусламжийн тасаг, халдвартын тасаг болон Шипагер, Жансая, Раушан, Мейрим ӨЭМТөвүүдийн байгалийн голомтот болон шинэ ба сэргэн тархаж буй | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зоонозын халварт өвчний дэгдэлтийн үеийн бэлэн байдлыг шалгаж, зөвлөмж өгөх, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд тарваган тахал болон хачигт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авах сургалт зохион байгуулж нийт 40 эмч эмнэлгийн ажилтнуудыг хамруулан 56ш санамж тарааж, мэдээ мэдээллийн самбарт урьдчилан сэргийлэх санамж хуудас байршуулж ажилласан. Аймгийн Онцгой Комиссын 2023 оны 04 дүгээр албан даалгавар Аймгийн Засаг даргын А/453 дугаар “Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай захирамжийн хуваарийн дагуу аймгийн Толбо, Бугат, Буян, сумдад хяналт шалгалт хийж, шалгалтад 241 тээврийн хэрэгсэл 335 иргэнийг хамруулсан ба үүнээс 2 иргэний 2 тээврийн хэрэгслээс 4 ширхэг алтайн тарвага, 2 ширхэг ТОЗ-8 маркийн калибр буу хурааж зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 4 дэх заалтын дагуу иргэн бүрийг 300 нэгжээр торгож 4 тарваганы экологи эдийн засгийн үнэлгээ болох 3680000 төгрөг барагдуулан ажилласан. | |
| 3.1.2 | “Халдварт өвчнөөс сэргийлэх, тандах“ арга хэмжээний төлөвлгөө боловсруулан хэрэгжүүлнэ. | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 97.8 | 98%-иас доошгүй | Томуугийн харуулдан тандалтын нэгжүүдийн эмч, мэргэжилтэнг чадавхижуулах “ Баян-Өлгий аймаг дахь сургалтыг зохион байгууллаа.<br>Томуугийн тандалтын интернэтэд суурилсан цахим системийн шинэчлэлт, хөгжүүлэл, улиралын томуу болон цар тахлын хүндрэлийн үнэлгээний ашиглалтыг танилцуулах зорилгоор 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Эрүүл мэндийн газрын бэлтгэгдсэн мэргэжилтнүүд сургалт зохион байгуулж, сургалтанд томуу, томуу төст өвчний тандалтын мэдээ өгөх 11 сум, 4 өрхийн дүн бүртгэлийн 16 эмч, эмнэлгийн ажилтнуудыг хамруулсан. “Гепатиттай тэмцэх Дэлхийн өдөр”-ийг тохиолдуулан Нэгдсэн эмнэлгийн халдвартын алба, тасагтай хамтран амбулаториор үйлчлүүлсэн 300 иргэнд Вируст | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гепатитын халдвараас хэрхэн сэргийлэх талаар сургалт сурталчилгаа хийж 100 иргэнийг В, С вирусын хурдавчилсан шинжилгээнд хамруулж В гепатит 2, С гепатит 1 тохиолдлыг тус тус илрүүлэн халдвартын эмчийн хяналтад авсан.<br>Манай аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар хоолны хордлого бүртгэгдээгүй байна. Аймгийн төвийн сургууль, цэцэрлэгийн багш, ажилтнуудад нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах удирдамж гаргаж, 20 цэцэрлэгийн гал тогооны эрүүл, ахуй халдвар хамгаалаллын байдалд дэмжлэгт хяналт үнэлгээ хийж, нийт 300 ажилчдад Хоолны хордлогоос урьдчилан сэргийлэх тухай ажлын байрны сургалт явуулсан. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр Хоолны хордлогоос сэргийлэх тухай 3 удаа мэдээлэл өгсөн. Олон улсын гэр бүлийн өдөр, Музейн талбайд “Эрүүл мэнд ба сайн сайхан оршихуйг дэмжих" сэдэвт өдөрлөгийн үер халдварт өвчнөөс сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Хоолны хордлогоос сэргийлэх, Салхин цэцэг, Улаан бурхан, Гэдэсний халдвараас сэргийлэх талаар мэдээлэл сургалт сурталчилгаа хийж, 210 ширхэг гарын авлага тараасан. Тус сургалтын үр дүнд ард иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилсэн. “ЭМС-ын 2018 оны А/527 дугаар тушаалын хэрэгжилт, тандалт судалгаанд анхаарах, салхин цэцэг, гар, хөл амны өвчний тандалт, хариу арга хэмжээ, судалгааны маягт хөтлөлт, томуу, томуу төст өвчний хариу арга хэмжээг эрчимжүүлэх” талаар цахим уулзалтыг өрх сумдын эрүүл мэндийн төвийн дарга ,нийгмийн эрүүл мэндийн ажилтан зэрэг 20 холбогдох эмч нарт цахим уулзалт, сургалтыг зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж, мэдээлэл хүргэн ажиллалаа. | |
| 3.1.3 | Нийт хүн ам болон зорилтот бүлэгт зориулсан Томуугийн | - | Цахим хандалтын | - | Хүн амын 30-аас | Харьяа эрүүл мэндийн байгууллагуудад ЭМС-ын А/583, А/482, А/373 дугаар тушаалуудыг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | болон коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахалтай тэмцэх, сэргийлэх,мэдээлэл, сургалт, сурталчилгааг цахим хэлбэрээр тогтмол зохион байгуулна. | | тоо | | доошгүй хувь | хүргүүлэн, мэргэжлийн арга зүйн зааварчилгаа өгч, томуу, томуу төст өвчин, Коронавируст халдварын долоо хоногийн мэдээнд дүн шинжилгээ хийж, зөвлөмжийг байгууллагын албан мэйл хаягаар 48 удаа хүргүүлсэн. ЭМС-ын 2020 оны А/583 дугаар тушаалд заагдсанаар томуугийн тандалтын тогтолцоонд суурилан коронавируст халдварын тархалтыг тандах зорилгоор тандалтын нэгжүүдээс тохиолдлын тодорхойлолтын дагуу 14 хоногт 1 удаа 20 хүртэлх сорьцыг цуглуулж, аймгийн Вирус судлалын лабораторид хүргүүлж нийт 620 хүнийг хамар, залгиурын арчдас авч 44 сорьцонд амьсгалын замын халдвар үүсгэгч бусад вирус илрүүлэхшинжилгээгээр 40 (90.9%) сорьцонд А хүрээ, 4 (9%) сорьцонд В хүрээний вирус тус тус илэрсэн байна.<br>Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар орон нутгийн Дербес, 9 цагийн радиогоор 8 удаа, 16 удаагийн давтамжтай сэрэмжлүүлэг мэдээлэл хүргүүлсэн. Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт хэвтсэн хүүхдийн томуугийн тандалттыг 6 удаа хийж, зааварчилгаа өгч, 5 удаа зөвлөмж хүргүүлэн ажилласан. 2023 оны томуу, томуу төст өвчний долоо хоногийн мэдээнд дүн шинжилгээ хийж, харьяа сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн мэйл хаягаар 48 удаа хүргүүлсэн. | |
| 3.1.4 | Халдварт өвчний үед халдваргүйжүүлэлтийн бодисын нөөц бүрдүүлэн, урьдчилан сэргийлэх, голомтын халдваргүйжүүлэлтийн байдалд үнэлгээ хийж, шаардлагатай арга хэмжээ зохион байгуулна. | - | Халдваргүй жүүлэл тийн байдалд хийсэн үнэлгээний тоо | - | 10-аас доошгүй | Эрүүл мэндийн газрын баталсан удирдамжийн дагуу аймгийн нэгдсэн эмнэлэг, хувийн ортой 5 эмнэлэгт халдварт өвчний үеийг бэлэн байдал, халдваргүйжүүлэлтийн бодисын нөөц , голомтын халдваргүйжүүлэлтийн байдалд дэмжлэгт хяналт үнэлгээ хийсэн. Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны 12 сарын А/75, А/76, А/77, А/78, А/79 болон 2023 оны 06 дугаар сарын 05-ний өдрийн А/26 дугаар тушаалаар нийт 33 нэр төрлийн эм, түргэвчилсэн оношлуур, хамгаалах хэрэгсэл, хүчилтөрөгчийн баллон дагалдах хэрэгслээр харьяа эрүүл мэндийн байгууллагуудад | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хувиарлалт хийгдсэн.<br>Жилийн эцийн байдлаар Нэгдсэн эмнэлэг, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд 36 нэр төрлийн 56,0 сая төгрөгийн 90 хоногт хүрэлцээтэй ариутгал хардваргүйтгэлийн бодисын нөөцтэй байгаа ба Эрүүл мэндийн газарт 10 нэр төрлийн 21.0 сая төгрөгийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөцтэй байна.<br>Харьяа 12 сум, 1 тосгоны эрүүл мэндийн төвүүдийн 2023 оны хагас, бүтэн жилийн тайланд үнэлгээ хийж, халдварт өвчний хариу арга хэмжээ, халдварт өвчин болон эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой халдвар, халдварт өвчний бэлэн байдалыг сайжруулах зөвлөмж хүргүүлсэн.<br>Аймгийн Зооноз өвчин судлалын төв нь<br>өөрийн бсайгууллагын төсвийн хүрээнд нөөц бололцоогоо ашиглан зоонозын халдварын хүний дуудлагын үед шаардлагатай 8 нэр төрлийн хувийн хамгаалах хувцас хэрэгсэл, 7 нэр төрлийн халдваргүйжүүлэлтийн бодис, 54 нэр төрлийн оношлуур урвалж, тэжээлт орчин, эм бэлдмэл, 7 нэр төрлийн багаж хэрэгслийн нөөц бүрдүүлсэн. | |
| 3.1.5 | Зорилтот бүлгийн хүн амыг Томуугийн болон товлолын вакцинжуулалтад хамруулах нөлөөллийн ажил зохион байгуулж хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | - | Зохион байгуулсан нөлөөллийн ажлын тоо | - | 5-аас доошгүй | ЭМСайдын 2023 оны 10-р сарын 10-ны өдрийн А/358 дугаар тушаалын дагуу 2023 оны 10-р сарын 20-ны өдөр ЭМГ-ын даргын А/49-р тоот тушаал батлагдаж “Дархлаажуулалтын ээлжит 10 хоног”-ийг 2023 оны 10 дугаар сарын 20-аас эхлэн “Томуугаас сэргийлье” уриан дор зохион байгуулж байна. Манай аймагт нийт 10170 хүн тун вакцин хуваарилагдан ирсэн ба 2023 оны 12-р сарын 08-ны өдрийн байдлаар 2-5 насны хүүхэд 5267, жирэмсэн эх 167, архаг хууч өвчтэй болон 65-аас дээш насны 3250 хүн, эмч эмнэлгийн ажилчдын 537 хүн тус тус хамрагдаж нийт 9221 хүн хамрагдаж 90%-тай байна. | 90% |
| 3.1.6 | Хүн амд шинэ болон сэргэн тархаж буй халдвар, зоонозын шалтгаант өвчнөөс сэргийлэх сургалт, сурталчилгаа зохион | | Сургалтад хамрагдсан иргэдийн хувь | | Хүн амын 30-аас доошгүй хувь | Манай аймгийн хэмжээнд шинэ болон сэргэн тархаж буй халдвар, зоонозын шалтгаант өвчнөөс сэргийлэх сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх 2023 оны ЭМГ-ын даргаар батлуулан, календарчилсан төлөвлөгөөний | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулна. | | | | | дагуу 14 хоног тутам харьяа эрүүл мэндийн мэндийн байгууллагуудаас сургалт, сурталчилгааны тайлан авч хяналт тавьж ажилласан. Үүнд 2023 оны байдлаар 65 удаагийн 25820 иргэнд шинэ болон сэргэн тархаж буй халдварын талаар сургалт, сурталчилгаа хийсэн байна. ЗӨСТ нь нь 2023 онд гүйцэтгэх зоонозын халдварт өвчний хариу арга хэмжээний календарьчилсан төлөвлөгөө болон ЗӨСТөвийн сургалт сурталчилгааны хөтөлбөр батлуулж, баталсан хуваарийн дагуу үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаа. Нийт 5 удаа эрүүл мэндийн эмч ажилчдыг хамруулсан сургалт хийгдсэнээс 4 нь тэнхим, 1 цахим сургалт байгаа ба нийт 93 эмч, эрүүл мэндийн ажилчдыг хамруулсан байна. Байгууллагын ажилчдын мэдлэгийг сэргээх, бататгах, дээшлүүлэх зорилго бүхий хөтөлбөрийг сургалт сурталчилгааны багаас боловсруулан батлуулж, эмч, мэргэжилтнүүд хөтөлбөрийн дагуу өөрт хуваарьлагдсан сэдвүүдийн хүрээнд сургалтын материал бэлтгэж нийт 20 сэдвээр сургалт явууллаа. Глобаль сангийн санхүүжилтээр сумын эрүүл мэндийн төвөөс 270 хүний 540 цэрний сорьцыг тээвэрлэж, нян судлалын шинжилгээнд хамруулсан.2021-2022 онд ажлын байрнаас сүрьеэгийн шинэ тохиолдол бүртгэгдсэнтэй холбоотой Хилийн цэргийн 0285 дугаар ангийн 250 албан хаагч, Улаанхус суманд үйл ажиллагаа явуулдаг хилийн цэргийн ангийн 60 албан хаагч, Жаннур ТББ 40 хүүхэд, ажилтан, 2-12 жилийн сургуулийн 200 сурагч, 40 иргэн цээжний гэрлийн шинжилгээ, асуумж судалгааны арга, цэрний нян судлалын шинжилгээний аргаар идэвхтэй илрүүлэг үзлэгт хамруулсан.<br>Аймгийн Нэгдсэн эмнэлгийн сүрьеэгийн амбулаторийн үзлэгт 4331 иргэн хамрагдсан ба үнээс анх 624, давтан 276, урьдчилан сэргийлэх 3386, идэвхтэй хяналт 45 байна. | |
| Стратеги төлөвлөгөөний зорилго 4. Хүн амын дунд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлэн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх | | | | | | | |
| 4.1 | Зорилт 1. Нөхөн үржихүйн эрүүл мэнд, | | Зохион | - | 1 | | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | өсвөр үеийн эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2.2.16, Монгол Улсын Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын 2.4.1.8 | | байгуулсан сургалтын тоо | | | | |
| | | | Хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо | - | 33 | | |
| 4.1.2 | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд зохилон тохиолдох сэтгэцийн эмгэгийг эрт илрүүлэх, зөвлөгөө өгөх ур чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулна. | 6,0 | Зохион байгуулсан сургалтын тоо | - | 1 | Баяннуур, Алтай, Цэнгэл Сагсай, Булган СЭМТ-ийн нийт 10 эмчийг “Гамшигийн үеийн сэтгэл зүйн бэлэн байдал” зөвлөгөө өгөх ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулсан. Мөн Аймгийн 13 сум, 4 өрхийн эрүүл мэндийн байгууллагуудын эрхлэгч, дарга нар болон нийгмийн ажилтануудад Сэтгэцийн эрүүл мэндийн боловсролыг хүн бүрд аяны ерөнхий төлөвлөгөө, удирдамжийг танилцуулж. мөн зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэгийг эрт илрүүлэх, зөвлөгөө өгөх ур чадвар эзэмшүүлэх сургалтыг цахимаар /ZOOM-ээр/ хийсэн. Нийт 38 эмч, эмнэлгийн ажилчид хамрагдсан болно. | 100% |
| | | - | Хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо | - | 33 | | |
| 4.1.3 | Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн гэр бүл төлөвлөлтийн арга хэрэгслийн хэрэглээний хангалтыг сайжруулж, урьдчилан сэргийлэх үзлэгийн хамралтыг нэмэгдүүлнэ. | | Жирэмслэлтээс сэргийлэх эм, хэрэгслээр хангагдсан нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн хувь | 58.4 | 60%-иас доошгүй | НҮЭМ, БЗДХ, Эрэгтэйчүүдийн НҮЭМ, Эрүүл зөв хооллолт, дасгал хөдөлгөөний ач холбогдолын чиглэлээр төрийн болон төрийн бус 25 байгууллагууд, мөн хилийн цэргийн 0285 дугаар ангийн бие бүрэлдэхүүн болон 5 застав, зэвсэгт хүчний 340 дүгээр анги, хилийн цэргийн 0165 дугаар ангийн бие бүрэлдэхүүнд нийт 710 албан хаагчид ажлын байрны сургалт явуулсан. 10 медресегийн нийт 38 багш, 56 сурагчид Дотуур байрны эрүүл ахуйн стандарт, Хэвийн биеийн юмны мөчлөг, Өсвөр насны НҮЭМ сэдвээр сургалт явуулсан. МУБИС-ийн Баян Өлгий аймаг дахь салбар сургууль, МСҮТ-ийн оюутан, МСҮТ-ийн дотуур байрны оюутнуудад Гэр бүл төлөвлөлт, түүний аргууд, НҮЭМ, үр хөндөлтийн талаар сургалт явуулж нийт 84 оюутан хамрагдсан. | 100% |
| | | | Үзлэгт хамрагдсан НҮН-ны эмэгтэйчүүдийн хувь | 67.1 | 67%-иас доошгүй | | |
| 4.1.4 | 18-35 хүртэлх насны залуучуудын эрүүл мэндийг дэмжих нөлөөллийн ажил зохион байгуулна. | - | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | - | - | Аймгийн хэмжээнд “Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх” ажлын хэсэг байгуулан 18-35 хүртэлх насны залуучуудын эрүүл мэндийг дэмжиж цахим пейж хаягаар байнгын мэдээ, мэдээлэлээр ханган ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Хамрагдсан залуусын тоо | - | - | 2.”Бидэнд тамхи биш Хүнс хэрэгтэй” сарын аянг зохион байгуулан нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулсан.<br>3.Идэвхтэй хөдөлгөөн, эрүүл хооллолт, эрүүл орчинд амьдрах талаар аймгийн төв талбайд 18-35 хүртэлх насны залуучуудыг түлхүү хамруулан “Эрүүл Монгол Хүн” үндэсний фестивал зохион байгуулан ажилласан. Сайн дурын зөвлөгөө өгөх кабинетээр дамжуулан Залуучуудын дунд урьдчилан сэргийлэх аюулгүй байдал ХДХВ/ДОХ болон бэлгийн замаар дамжих халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр тогтмол ухуулга сурталчилгаа хийж давхардсан тоогоор 1250 хүнд зөвлөгөө өгч ажилласан. | |
| 4.1.5 | Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй байгуулсан гэрээний нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгжилтэд үнэлгээ хийнэ. | - | Нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгжилтийн хувь | - | 70%-иас доошгүй | Өрхийн эрүүл мэндийн төвийн хагас жилийн гэрээний биелэлтийн үнэлгээ хийх үед хамт хийгдсэн. | 100% |
| 4.1.6 | Сургуулийн өмнөх болон сургуулийн хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн боловсрол олгох хичээлийн чанар, хүртээмж, амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах, осол гэмтлээс сэргийлэх, “Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар дундын оролцоог хангах нөлөөллийн ажил зохион байгуулна. | - | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | - | 5-аас доошгүй | “Хүүхэд танд хуулийн мэдлэг олгоё” сарын аяны хүрээнд Эрүүл мэндийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын газар, Улаан загалмайн нийгэмлэг хамтран ерөнхий боловсролын сургуулиудын 7, 8 ,9, 10, 11-р ангийн 1660 сурагчдад “Дэлгэцийн донтолт” сэдвээр сургалт явууллаа.<br>12 дугаар сарын 1-ний өдрийг дэлхий нийтээрээ ХДХВ/ДОХ-ын асуудалд анхаарал хандуулах өдөр болгон тэмдэглэн өнгөрөөдөг. Энэ жил “Олон нийтийн манлайллыг дэмжье" уриан дор ХДХВ/ДОХ-той тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх, халдвараас урьдчилан сэргийлэх, хүн бүрийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор нөлөөллийн ажлыг Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн БЗДХ-ын кабинет, Эмэгтэйчүүдийн Арулар ТББ, Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран Ерөнхий Боловсролын 1 дүгээр сургуулийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 11,12-р ангийн 80 сурагчдын дунд ХДХВ/ДОХ-ын асуудалд анхаарал хандуулах өдрийг таниулан сурталчлах, мэдлэг олгох сургалт явуулж, АХА тэмцээн зохион байгуулан 7 сурагчийг шагнан урамшуулж, цаашдын сурлагаас нь  амжилт хүсэж ,тус өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ. | |
| 4.1.7 | Сэтгэцийн эрүүл мэнд, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэл зүйн тусламж үйлчилгээг үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл, түүний талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх, осол гэмтлээс сэргийлэх зэрэг салбар дундын хамтын ажиллагааг хангуулах нөлөөллийн ажил зохион байгуулна. | 1,5 | Зохион байгуулсан үйл ажиллагаа ны тоо | - | 5-аас доошгүй | Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын газартай хамтран “МАНСУУРУУЛАХ СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСТОЙ ХОЛБООТОЙ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ӨСВӨР НАСНЫ ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫГ ХОРТ ЗУРШЛААС АНГИД БАЙЛГАХ ЧИГЛЭЛЭЭР 2023 ОНД АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ “АНЗААР” АРГА ХЭМЖЭЭНИЙ хүрээнд Манай эрүүл мэндийн газар дараах хоёр арга хэмжээг зохион байгуулсан.<br>1-р зэрэглэлийн хоёр эмийн сангуудад хяналт, үнэлгээ хийж холбогдох зөрчлүүдийг прокурорд хүргүүлж ажилласан.<br>Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эм зүйч эмнэлгийн ажилтануудад Мансууруулах эм, сэтгэц нөлөөт эмийн ойлголт сэдвээр сургалт семинар явуулсан. Нийт 46 эмнэлгийн ажилтад хамрагдсан. | 100% |
| Стратеги төлөвлөгөөний зорилго 5. Эрүүл мэндийн мэдээ, мэдээлэл болон мэдээллийн дэвшилтэт технологийг нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээ үзүүлэх, шийдвэр гаргахад ашиглаж тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах | | | | | | | |
| 5.1 | Зорилт 1. Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийн техник болон телемидцин,  програм хангамжийг хөгжүүлж, хэвийн аюулгүй ажиллагааг хангах“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2.2, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогыг 2020-2026 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө 7.5 МУ-ын ЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1 | | Хурал хийсэн тоо | 28 | 1 | 24 | 100% |
| | | | Сургалт хийсэн тоо | 40 | 3 | 159 | |
| | | | Мэдээлэл хийсэн тоо | 3 | 3 | | |
| 5.1.2 | Телемедицин буюу зайн оношлогоо, Zoom программ ашиглан эрүүл мэндийн | - | Хурал хийсэн тоо | 1 | 1 | Аймгийн Эрүүл мэндийн газрын харьяа Нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг нь ЭХЭМҮТөвтэй алсын зайн технологиор | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагуудтай мэдээлэл солилцох, сургалт, хурал зохион байгуулна. | | | | | холбогдсон. 2023 оны 12 сарын байдлаар Нэгдсэн Эмнэлэг бусад байгууллагуудтай ZOOM, Google meet цахимаар 24 удаа холбогдож, хурал хийж, харьяа байгууллагууд болон дээд шатны байгууллагуудтай хамтарч 159 удаа сургалт зохион байгуулсан. Үүнээс телемедициноор 8 удаа холбогдсон байна. | |
| | | | Сургалт хийсэн тоо | 8 | 2 | 2023 оны 12 сарын байдлаар эрүүл мэндийн байгууллагууд ZOOM, Google meet цахимаар 159 удаагийн сургалтыг зохион байуулсан. | |
| | | | Мэдээлэл хийсэн тоо | 4 | 2 | Аймгийн Эрүүл мэндийн газар дээд шатны байгууллага мөн харьяа байгууллагууд болох АНЭ, сум, өрхийн ЭМТ-үүдтэй 159 удаа сургалт, мэдээлэл хийсэн. | |
| Стратеги төлөвлөгөөний зорилго 6. Хүн амын дунд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлж, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлэн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх | | | | | | | |
| 6.1 | Зорилт 1. Хүн амд эрүүл мэндийн боловсролыг олгох арга хэмжээг зохион байгуулж, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх /Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2.2.3, Монгол Улсын Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын 2.4.1.7, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.2.2, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2.1.5.3**/** | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 96.6 | 97%-иас доошгүй | 100% | 100% |
| | | | Хамтран ажилласан хэвлэл мэдээллийн байгууллагын тоо | 3 | 3 | 3 | |
| | | | Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо | 4 | 6 | 6 | |
| 6.1.1 | Хүн амд зөв дадал эзэмшүүлэх сургалт, сурталчилгаа, аян зохион байгуулах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ. | 1,6 | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 96.6 | 97%-иас доошгүй | I-IV Эрүүл мэндийн сайдын А/139 дүгээр тушаалын дагуу зохион байгуулагдах эрт илрүүлэг үзлэгийг сурталчлах чиглэлээр төрийн 22 байгууллагын 320 албан хаагч, хилийн цэргийн 0285 ангийн бие бүрэлдэхүүн болон 1-5 дах бүх заставуудын 150, хилийн цэргийн 0165 дугаар ангийн 150, зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн 150 бие бүрэлдэхүүнд сургалт явуулсан. Халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар иргэд, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдын мэдлэг, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хандлагыг сайжруулах, нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, ухуулга нөлөөллийн арга хэмжээний хүрээнд "Архи тамхины хэрэглээний тухай буруу ойлголтууд" "ХБӨ үүсгэх эрсдэлт хүчин зүйлс, сэргийлэх арга"-ын талаар 470 хүнд мэдээлэл хүргүүлсэн. /төрийн байгууллага/ | |
| 6.1.2 | Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах хувь хүн, гэр бүл, хамт олны оролцоог сайжруулж эрүүл мэндийг дэмжигч байгууллага, өрх, иргэний тоог нэмэгдүүлнэ. | 3,0 | Эрүүл мэндийг дэмжигч байгууллагын тоо | 4 | 6 | Эрүүл мэндийн сайдын А/139 дүгээр тушаалын дагуу зохион байгуулагдах эрт илрүүлэг үзлэгийг сурталчлах чиглэлээр төрийн 22 байгууллагын 320 албан хаагч, хилийн цэргийн 0285 ангийн бие бүрэлдэхүүн болон 1-5 дах бүх заставуудын 150, хилийн цэргийн 0165 дугаар ангийн 150, зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн 150 бие бүрэлдэхүүнд сургалт явуулсан. Халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар иргэд, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдын мэдлэг, хандлагыг сайжруулах, нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, ухуулга нөлөөллийн арга хэмжээний хүрээнд "Архи тамхины хэрэглээний тухай буруу ойлголтууд" "ХБӨ үүсгэх эрсдэлт хүчин зүйлс, сэргийлэх арга"-ын талаар 470 хүнд мэдээлэл хүргүүлсэн. /төрийн байгууллага/ | 100% |
| | | | Нөлөөллийн ажил зохион байгуулсан байгууллагын тоо | - | 20 | | |
| 6.1.3 | Орон нутгийн мэдээллийн хэрэгслээр хүн амд эрүүл мэндийн боловсрол төлөвшүүлэх мэдээлэл, сурталчилгааг зохион байгуулна. | 2,5 | Хамтран ажилласан хэвлэл мэдээллийн байгууллагын тоо | 3 | 3 | Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр /Дербес ТВ, орон нутгийн радио/ болон цахим вэб хуудсаар ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа, мэдээ, мэдээллийг 1530 удаа зохион байгуулсан болно | 100% |
| | | | Мэдээллийн тоо | 554 | 500-аас доошгүй | | |
| 6.2.1 | Зорилт 2.Халдварт, халдварт бус өвчлөлийг эрт илрүүлж, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлээс сэргийлэх "Алсын хараа-2050" МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2.2.1, 2.2.2,2.2.5, МУ-ыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.2.2, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл | | Удирдамжийн хэрэгжилтийн хувь | 100 | 100 | | 100% |
| | | | Зохион байгуулсан аяны тоо | 2 | 1 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагаа хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.1/ | | | | | |
| 6.2.2 | Дархлаажуулалтын аян зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллана. | | Удирдамжийн хэрэгжилтийн хувь | 90 | 100 | 2023 оны 5-р сарын 29-ээс 06 сарын 10-ны хооронд 10 хоног нэмэлт дархлаажуулалтын ЭМС-ийн А/180, А/188-р тоот тушаал, Аймгийн Засаг даргын А/273 захирамж, Эрүүл мэндийн газрын А/24, А/25 тушаалаар Улаанбурхан, улаануud өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 10 сараас 8 насны хүүхдүүдийг нэмэлтээр дархлаажуулах 20500 хүн тун вакциныг татан авч явуулын хэлбэрээр болон байнгын цэгт дархлаажуулалтанд хамруулж, үйл ажиллагааг явуулж байна. Одоогийн байдлаар нийт 10 сараас 8 насны 15363 хүүхдийг хамруулсан ба 73%-тай байна | 100% |
| | | | Зохион байгуулсан аяны тоо | 2 | 1 | | |
| 6.3.1 | “Цэвэр орчин-Хоггүй Өлгий ” аян зохион байгуулна. | | Стандартын ариун цэврийн байгууламжийн тоог 40-өөр нэмэгдүүлэх | - | - | 2023 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбоотой байгууллагын гадны талын цэвэрлэгээг сард 1 удаа хийж байна. Хавар, намрын Бүх нийтийн цэвэрлэгээний үер Эрүүл мэндийн газрын алба хаагчид Өлгий хотоос гарах, орох 6 чиглэлийн дагуу хуваарьт газар болон байгууллагын ойр орчмын 50 м газрын цэвэрлэгээг хийж, 3 портер хогийг ачуулж, хогийн нэгдсэн цэгт хүргэж ажилласан. | 100% |
| 6.3.2 | | | Ил задгай талбайд байрлах нүхэн жорлон, бохирын цооногийг арилгасан сумдын тоо | - | - | | |
| 6.3.3 | Стандартын ариун цэврийн байгууламжтай эрүүл мэндийн байгууллагын тоог нэмэгдүүлнэ | | Стандартын ариун цэврийн байгууламжтай эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь | - | 60 | Ариун цэврийн байгууламжийн судалгаа: Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын ариун цэврийн байгууламжид судалгаа хийсэн ба судалгаанд аймгийн Нэгдсэн эмнэлэг, ЗӨСТ, 5 хувийн эмнэлэг, 12 сум, 2 тосгон, 4 өрхийн эрүүл мэндийн төв, нийт 24 нэгжийг хамааруулсан. Судалгааны үр дүн:. Алтанцөгц, Бугат, Дэлүүн, Цэнгэл, Улаанхус сумын эрүүл мэндийн төвүүд төвлөрсөн ариун цэврийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууламж болон нүхэн жорлон хоёуланг нь ашигладаг. Эрүүл мэндийн байгууллагуудын 25% нь дотоод ариун цэврийн байгууламж , 43 % нь гадны ариун цэврийн байгууламж, 32% нь хоёуланг нь ашигладаг байна. Эрүүл мэндийн байгууллагуудад нийт 19 нүхэн жорлон байдаг бөгөөд үүний 11 буюу 57,8% нь сайжруулсан, 8 буюу 42,2% нь Нүхэн жорлон ,угаадасны нүх техникийн шаардлага MNS 5924:2015 стандартын шаардлага хангаагүй байна. Гадна байрлах ариун цэврийн байгууламж ашиглаж байгаа нийт 15 нэгжийн 18 нүхэн жорлонгийн 6 нь сайжруулсан, 5 нь стандартын шаардлага хангахгүй нүхэн жорлон ашиглаж байна. Эрүүл мэндийн төвүүдийн 6 буюу 39% нь ажилчдад зориулсан тусдаа ариун цэврийн байгууламжтай, 11 буюу 61% нь амбулаториор үйлчлүүлэгчид, эрүүл мэндийн ажилтан, хэвтэн эмчлүүлэгчид хамт ашигладаг ариун цэврийн байгууламжтай байна. Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт: Эрүүл мэндийн байгууллагууд өрөө тасалгаа болон ариун цэврийн өрөө, суултуур, угаалтуурыг жавелион, нүхэн жорлонг жавелион, хлорын шохойгоор халдваргүйжүүлэлт хийдэг байна. | |
| 6.3.4 | “Цэвэр агаар“ аян зохион байгуулах | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 92.1 | 92%-иас доошгүй | Цэвэр агаар аянд харьяа байгууллагуудаас нийт 6 байгууллага нэгдэж. үйл ажиллагаа зохион байгуулсан. | 100% |
| 6.3.5 | “Ус орчны эрүүл ахуйн” төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажиллана. | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 83.3 | 85%-иас доошгүй | Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/24 тоот “Ундны усны чанар аюулгүй байдалд<br>урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу аймгийн төвийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн өөрсдийн гаргасан төвлөрсөн бус усан хангамжийн эх үүсвэрийн гүний худаг болон энгийн гар худгийн усны чанарт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн хяналт шалгалтад нийт 24 гүний худаг, 7 энгийн гар аргаар гаргасан худгийн уснаас дээж авч аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтсийн итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамруулж, шинжилгээний дүнд үнэлгээ хийж ажилласан. Шинжилгээнд нийт 31 худгаас 62 сорьц авч тус бүрийг 13 үзүүлэлтээр шинжилгээнд хамруулж, шинжилгээний дүнг Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах, Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандарттай харьцуулахад химийн шинжилгээгээр нийт ундны усны 2,5% нь кальци, 2,5% нь магни, 7,5% нь нитрат, 2,8% нь хатуулгийн хэмжээ нь стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс их гарсан, нян судлалын шинжилгээгээр нийт ундны усны 27,5% нь гэдэсний савханцар буюу E.Coli, 2,5% нь гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян буюу сальмонелла, 2,5%, нь нянгийн тооотой гарч, ундны усны холбогдох стандартын шаардлага хангаагүй үзүүлэлттэй гарсан байна.<br>Дербес телевизд хэлэлцүүлэгт оролцож, "Усаар дамжих халдварт болон халдварт бус өвчнүүд, хэрхэн урьдчилан сэргийлэх" талаар ард иргэдэд мэдээлэл өгсөн.<br>Харьяа аймгийн мэргэжлийн хяналтын газарт шинжилгээнд ундны уснаас дээж авч өгч, Нүхэн жорлонг хэрхэн цэвэрлэж, халдваргүйжүүлэх талаар, түүхий ус уухгүй байх, усны савыг зөв цэвэрлэх, гарын эрүүл ахуйг сахих талаар гарын авлага өгч, заавар зөвлөмж өгч ажиллаж байна.<br>"Тирлик", "Ахдам", "Мал"-ын захад хүнсний аюулгүй байдал, орчны цэвэрлэгээ, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг хангуулахаар халдваргүйтгэл хийлгэж, хяналт тавьж ажилласан. | |
| Стратеги төлөвлөгөөний зорилго 7. Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах замаар өвчлөл эндэгдлийг бууруулах /"Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээний төлөвлөгөө 2021-2024 он/ | | | | | | | |
| Эх, нярайн тусламж үйлчилгээ | | | | | | | |
| 7.1 | Эх, нярайн тусламж үйлчилгээг сайжруулах, эндэгдлийг бууруулах арга хэмжээ авч ажиллана. | - | Эх нярайн эндэгдлийн түвшин | Эхийн эндэгдэл -72,2<br>Нярайн | Эхийн эндэгдэл-19.8<br>Нярайн эндэгдл | ЭМС-ын А/263 дугаар тушаалын дагуу эмнэлгийн нөхцөлд эндсэн 5 хүртэлх хүүхдийн эндэгдлийг магадлан хэлэлцэх хурлыг хийж дүгнэлт гаргаж, 3 удаа зөвлөмж хүргүүлсэн. 2. ЭМС-ын А/550 тушаалын дагуу эхийн ноцтой | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эндэгдлийн түвшин-8,3 | ийн түвшин-6,3 | хүндрэлийн хэлэлцүүлгийг зохион байгуулж, 3 удаа зөвлөмж хүргүүлсэн.<br>3. "Нярайд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах" хэлэлцүүлэг зохион байгуулж, зөвлөмж хүргүүлсэн. нийт 25 эмч, сувилагч оролцсон<br>4. Өндөр эрсдэлтэй жирэмсэн эхийн хяналтыг сайжруулж, эхийн эндэгдлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд хянагдаж буй өндөр эрсдэлтэй жирэмсэн эмэгтэйг нэ төрөх тасгийн эх барих эмэгтэйчүүдийн хяналтад байлгахаар сар бүрийн 1-ний өдөр сум, өрхөөс нэрсийг авч төрөх тасагт хүргүүлж байна.<br>5. Төрөх тасагт эмгэг нярайн тасаг байгуулж, нярайн эмч нарыг өдрийн 8 цагаар ажиллуулж, 24 цагийн жижүүрт гарган, нярайн эрчимт эмчилгээний 2 өрөөг иж бүрэн тоног төхөөрөмжийг байрлуулан зохион байгуулж тусламж үйлчилгээг үзүүлж байна.<br>6. Жирэмсэн эхчүүдэд шуурхай үйлчлэх зорилгоор “нэг цэгийн үйлчилгээ” –г төрөх тасгийн амбулаторийн хэсэгт зохион байгуулж, дотрын эмч 1, хэт авиан оношилогооны 2 аппараттай жирэмсний хяналтын 2 эмч эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан -1 эмчийг ажиллуулдаг, умайн эсийн шинжилгээ, цахим бүртгэл, үтрээний наацийн шинжилгээ зэргийг нэг дор авч байна.<br>7. ЭМС А/318 тушаалын дагуу жирэмсний товлолын хугацаанд өрхийн эмч нарт хэдэн удаа үзүүлснийг судлахаар Мейрим, Жансая, Шипагер өрхийн эрүүл мэндийн төвийн 164 жирэмсний хяналтын хөтчид үнэлгээ хийсэн. үүнээс 8 удаа үзүүлсэн эхийн тоо-38, 7 удаа үзүүлсэн эхийн тоо-54, 6 удаа үзүүлсэн эхийн тоо-40, 5 удаа үзүүлсэн 22, 4 удаа үзүүлсэн эхийн тоо-6, 3 удаа үзүүлсэн эхийн тоо-4 байна.<br>8. ЭМС-ын А/611 тушаалын дагуу Баяннуур, Булган, Цэнгэл, Алтай, Сагсай сумын төрөлтийн түүхэд, Алтанцөгц, Баяннуур, Бугат, 4 өэмтөвийн жирэмсний хяналт хөтчид хяналт үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлсэн. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 9. Нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг болон нярайн хэсэгт мөрдөгдөх журам, зааврын хэрэгжилтэд этхэлтсийн даргаар ахлуулсан баг байгуулж хяналт үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлсэн.<br>10. Дутуу нярайн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор ЭЭМҮТ-ээс нярайн эмч ирж 3 хоногийн ажлын байрны сургалт хийж зөвлөгөө өгсөн.<br>11. "Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээ" баруун бүсийн сургалтыг зохион байгуулж 1 нярай, 1 эх барих эмэгтэйчүүдийн эмч, 2 нярайн сувилагч, 2 эх баригчийг хамруулсан<br>12. Эмгэг нярайн хэсгийн зохион байгуулалт, үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийж албан даалгавар хүргүүлсэн. албан даалгаврын биелэлт 50% байсан.<br>13. ЭХЭМҮТ-ийн перинатологийн эмгэг хэсгийн хяналтын батжаргал эмчтэй хамтран өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт "жирэмсний эрсдэлийг зөв үнэлэх сэдэвт сургалт зохион байгуулж, 15 эмч, сувилагч хамрагдсан. "эх барих эмэгтэйчүүд, нярайн тусламж үйлчилгээг сайжруулах" тусламж үйлчилгээний хүрээнд эх баригч нарт чадавхжуулах сургалт зохион байгуулсан. нийт-15 эх баригч оролцсон. | |
| 7.1.1 | Аймгийн засаг даргын 2021 оны А/76 захирамжаар батлагдсан " Нэрийн хяналт "-ын хэрэгжилтийг ханган ажиллах | - | Жирэмсний хяналт хувь | 0 | 50% | Нэрийн хяналтын мэдээг тогтмол авч нэгтгэн, өртөмтгий жирэмсэн эхийн мэдээллийг сар бүр төрөх тасагт хүргэн эргэх холбоотой ажиллаж байна. Нэрийн хяналтыг цахимжуулах зорилгоор google sheet программд оруулж байна. 2023 оны 11 сарын байдлаар шинээр хяналтад 2323 эх орсон байна. Өрхийн эрүүл мэндийн төвийн жирэмсэн эмэгтэйчүүдийг хянадаг эмч нарыг танхимаар, СЭМТөвийн эмч нарт цахимаар тушаалыг сэргээж дахин танилцуулан, хэрхэн ажиллах талаар арга зүйгээр ханган сургалт явуулсан. | |
| 7.1.2 | Эх хүүхдэд ээлтэй байгууллага шалгаруулах | 3 сая | Шалгарсан байгуулгын тоо | 0 | 3 | Аймгийн ИТХ-ын 2020 оны 77 дугаар тогтоолын дагуу ээлтэй байгууллага, болон салбар зөвлөл шалгаруулах үйл ажиллагааг 2023 оны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 03 дугаар сард шалгаруулах байсан болович материал ирүүлсэн 2 байгууллага шаардлага хангаагүй учир дахин зарлахаар болсон. | |
| Хүүхдийн тусламж үйлчилгээ | | | | | | | |
| 7.2 | Хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулах, эндэгдлийг бууруулах | - | Хүүхдийн эндэгдлийн түвшин | 20.9 | 12.1 | Хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулж, бага насны хүүхдийн идэвхтэй хяналтын хувийг нэмэгдүүлэх, хяналтыг чанаржуулах, эндэгдлийг улс, аймгийн дундаж түвшин хүртэл бууруулах олон ажлууд хийгдэж байгаа ч /сургалтууд, хяналт үнэлгээ г.м/ 1-5 насны хүүхдийн эндэгдэл өмнөх оноос 6 тохиолдлоор буурч, нялхсын эндэгдэл 45 тохиолдол бүртгэгдэж, өмнөх оноос 11 тохиолдлоор нэмэгдсэн. Харин гэрийн идэвхтэй хяналт 9,6% буюу өмнөх оноос 0,4%-р өссөн үзүүлэлттэй байна. | 100% |
| 7.2.1 | Харьяа байгууллагуудын эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр хэрэгжүүлж буй стандарт удирдамжийн байдалд хяналт үнэлгээ хийх | 1,5 сая | Хийгдсэн хяналт үнэлгээний тоо | 2 удаа | 2 удаа | Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу Аймгийн нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төв, бүх сумын эрүүл мэндийн төвүүдэд хяналт үнэлгээ хийж илэрсэн алдаа дутагдалуудыг газар дээр нь арилгуулж арга зүйн зөвлөгөө өгч ажиллсан. Бүх эрүүл мэндийн төвүүдэд хүүхдийн эмчийн үзлэгийн тустай өрөөтэй болгох стандартын шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр хангах, ХӨЦМ-ийн дагуу эмчлэх, суурь өвчтэй хүүхдийг илрүүлэх, эрүүлжүүлэн эмчлэх, 0-5 настай хүүхдийн идэвхтэй хяналт, 9,18,36 сартай хүүхдийн илрүүлэг, давтамжит гэрийн эргэлт зэрэг чиглэлүүдээр хяналт үнэлгээ хийсэн. | 100% |
| 7.2.2 | Эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгч эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтад хамруулах | 10 сая | Сургалтын тоо сургалтад оролцоч ийн тоо | 30 хүнд 1 удаагийн сургалт | 120 хүнд 4 удаагийн сургалт | ЭХЭМҮТөв, Аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран Хүүхдийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх,салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор ЭМГ-ын хурлын зааланд 2023 оны 9 сард нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасаг, өрх сумын нийт хүүхдийн эмч, нярайн сувилагч нийт 41 хүнийг хамруулсан онолын болон гардан үйлдэл, дадлага хосолсон үр дүнтэй сургалт зохион байгуулагдлаа. ЭХЭМҮТ-д "ХҮҮХДИЙН СУУРЬ | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | БОЛОН ЛАВШРУУЛСАН СЭХЭЭН АМЬДРУУЛАЛТ” сэдэвт ажлын байран дахь 10 хоногийн вакуумжуулсан сургалтад манай аймгаас 1 хүүхдийн эмч хамрагдсан. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн мэргэжилтний тав хүртэлх насны хүүхдийн хоол тэжээлийн хамааралт эмгэгийн талаарх ойлголт, мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор “Хүүхдийн хоол тэжээлийн цочмог дутлын цогц менежмент” баруун бүсийн сургалтыг Ховд аймгийн Эрүүл мэндийн газрын сургалтын танхимд 2023 оны 11-р сарын 24-28-ны өдрүүдэд НЭМҮТ-ийн үндэсний сургагч багш нар зохион байгууллаа. Сургалтанд манай аймгаас 2 мэргэжилтэн 2 хүүхдийн эмч оролцож сургагч багшийн сертификат гардан авлаа. | |
| 7.2.3 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан чанартай зохион байгуулна. /Алсын хараа 2050 2.2.11 заалт/ | 20 сая | Алслагдсан хүн амын эмнэлгийн тусламжид хамрагдсан тоо | 15% | 20 % | Манай аймаг алслагдсан багийн иргэдийг зуслангийн нүүдлийн үед эмнэлгийн тусламжийг ойртуулах зорилгоор, Улаанхус сумын Хөх хөтөл багийн их эмчийн салбар, Сагсай суманд багийн эмчийн салбар, Баяннуур суманд багийн эмчийн салбар, Алтанцөгц, Баяннуур сумдын эрүүл мэндийн төв, Ногооннуур сумын сум дундын эмнэлэг зуслангийн эмнэлгээр тусламж үйлчилгээг үзүүлдэг.<br>Малчдын нүүдлийн үетэй холбоотой эмнэлгийн тусламж үйлчилгээг ойртуулах зорилгоор Цэнгэл сум эрүүл мэндийн төв нүүдлийн их эмчийн салбарыг ажиллуулж яаралтай тусламж 51, амбулаторын үзлэг 63, гэрийн дуудлага 43, , диспансерийн хяналтын үзлэг 10,урьдчилан сэргийлэх үзлэг 210 -г тус тус хийсэн байна. | 100% |
| Стратеги төлөвлөгөөний зорилго 8. Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламжийн ачааллыг тэнцүүлж, хүн амд чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй “үйлчлүүлэгч төвтэй” тусламж үйлчилгээ үзүүлэх чадвар бүхий эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжинэ. | | | | | | | |
| 8.1 | Магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан эрүүл мэндийн байгууллагуудад явцын хяналт үнэлгээг хийх,зөвлөгөө өгөх | | Магадлан итгэмжлэгдсэн ЭМБ-ын тоо | 6 | 6 | 2023 онд магадланд орох 9 эрүүл мэндийн байгууллагын материалыг хянаж,явцын хяналт үнэлгээг хийх,зөвлөгөө өгч ажиллав. үүнд: “Бейс шипа”, “Жаншарапат”, “Фатиха” хувийн ортой эмнэлэг, булган сэмт тус бүр 2 жилээр, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ногооннуур сэмт 3 жилээр, Буянт, Баяннуур сэмт тус бүр 1 жилээр магадлан итгэмжлэгдэв. Дэлүүн сумын эмт нь 2023 оны 9-сарт магадлан итгэмжлэлд орж тэнцээгүй тул 11-сарт дахин орсон. буянт эмт 2023 оны 01-сарт магадлан итгэмжлэлд орохоор бэлдэж байна. Дэлүүн, Баяннуур сэмт-үүд нь хэдэн жилээр магадлан итгэмжлэгдэх нь эмя-ны зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар шийдвэрлэгдэнэ.<br>- 2022 онд магадлан итгэмжлэлд орсон Булган, Дэлүүн, Ногооннуур, Сагсай, Улаанхус, Бугат, Алтай, Алтанцөгц, Цэнгэл сумдын эмт-ийн, Хилийн цэргийн 0165 дугаар ангийн эмт, Шипагер өэмт, Ахсу рашаан сувилал, Сансар эмнэлгийн,<br>- 2023 онд магадлан итгэмжлэлд орсон Буянт, Баяннуур, Ногооннуур, Булган сэмт, “Бейс шипа”, “Жаншарапат”, “Фатиха” хувийн ортой эмнэлгүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын төлөвлөгөөг хянаж, эрүүл мэндийн хөгжлийн төвийн магадлан итгэмжлэл, лицензийн албад хүргүүлж, батлуулсан.<br>-эдгээр байгууллагуудын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан ба 2023 оны тайланг авч, дүн шинжилгээ хийж, дүгнэлтийг эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлэв | 100% |
| 8.1.2 | Харьяа эрүүл мэндийн байгууллагын чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэн, ЭМТҮЧАБ-ын талаар гарсан тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах, дэмжлэгт хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллах | 1 сая | Хяналт үнэлгээний тоо | 2 удаа | 2 удаа | ЭМГ-ын эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдал, магадлан итгэмжлэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн ортой эмнэлэг болон клиникүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба, багуудын цахим группэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын талаар байнга мэдээлэл солилцож ажиллаж байгаа.<br>-хяналт үнэлгээний ажлын хэсэг нь нэгдсэн эмнэлгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 21 тасаг, нэгжийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын багуудын, 4 өэмт, ногооннуур, толбо, дэлүүн, булган сумдын эмт-ийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын багуудын үйл ажиллагаа, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалд дэмжлэгт хяналт, үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэв.зөвлөмжийн хэрэгжилт дундажаар 85%.<br>-эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан “орон нутгийн эрүүл мэндийн байгууллагыг чадавхижуулж, магадлан итгэмжлэлд бэлтгэх нь” сэдэвт 9 удаагийн цахим цуврал сургалтад нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд, хувийн ортой эмнэлэг болон клиникүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба, багуудын гишүүд, нийт давхардсан тоогоор 540 хүн оролцов.<br>- үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдрийг тохиолдуулан эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан төрийн өмчийн эмнэлгүүдээс анх олон улсын магадлан итгэмжлэл авсан төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн туршлага судлуулах цахим сургалтанд бүх харьяа эмб-уудын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба, багуудын 71 гишүүдоролцож, цахимаар туршлага судлав. –тус эмнэлэгт эмг-ын эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн нь 2023 оны 10 дугаар сарт туршлага судалж, олж авсан мэдээллүүдээ харьяа эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн ажиллав.<br>-эрүүл мэндийн хөгжлийн төвийн эмнэлгийн тусламжийн явцад гарсан тохиолдол, эрсдлийг бүргүүлэх цахим программд бүх харьяа эрүүл мэндийн байгууллагуудын мэдээллийг оруулсан. цэнгэл суманд тохиолдсон ноцтой тохиолдлыг уг программд оруулсан.<br>-үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаар цахимаар үйлчлүүлэгчдээс судалгаа авч, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дүгнэв. үүнд 43 иргэн оролцсон ба иргэдийн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын талаар мэдлэг дутмаг, эрүүл мэндийн байгууллагуудын эмч, эмнэлгийн ажилтнуудын мэдлэг, харьцаа, хандлагыг байнга дээшлүүлж байх санал, хүсэлтүүд гарсан.<br>-эрүүл мэндийн яамнаас “эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага mns 7014:2023” стандартын сургагч багшаар бэлтгэгдсэн багш нар болох эмг-ын эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн ба нэгдсэн эмнэлгийн эрсдлийн менежер нар уг стандартын сургалтыг 5 удаа эмг-ын болон нэ, сэмт-ийн 80 мэргэжилтэн, эмнэлгийн ажилтнуудад зохион байгуулсан ба тайланг эмя-нд хугацаанд хүргүүлсэн.<br>-цаашдаа тус сургалтыг аймгийн эрүүл мэндийн салбарын нийт ажилтнуудад шат дараалан тасралтгүй зохион байгуулахаар төлөвлөж байна. -<br>уг стандартын хэрэгжилтийг эмя-аас ирүүлсэн үнэлгээний хуудсаар 23 харьяа эмб-уудыг үнэлж, үнэлгээний нэгдсэн дүнг эрүүл мэндийн хөгжлийн төвд хугацаанд хүргүүлэв. | |
| 8.1.3 | Тусгай зөвшөөрөл хүсэгчийн баримт бичгийн бүрдэлтийг хянаж, бэлтгэсэн ажлын байранд үнэлгээ хийх ажлыг зохион байгуулан, комиссын хурлаар хэлэлцүүлэх | - | Зохион байгуулсан хурлын тоо | 4 удаа | 4 удаа | Аймгийн тусгай зөшөөрлийн комисст хүсэлт ирүүлсэн 41 эрүүл мэндийн байгууллагын материал бүрдүүлэлтэд ажлын албаны гишүүд зөвлөгөө өгч, орон байрны үнэлгээ хийж, арга зүйгээр ханган ажиллав.<br>Тусгай зөвшөөрлийн комисс нь 9 удаа хуралдаж, комиссын шийдвэрээр 3 клиник, 4 эмийн санд тус бүр 5 жилээр шинээр тусгай зөвшөөрөл олгож, 3 ортой эмнэлэг, 6 клиник, 4 өэмт, 4 сэмт, 1 тосгоны эмт,2 ттэмт, 2 ахшмххк, 21 эмийн сан, нийт 50 эрүүл мэндийн байгууллагын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж, 9 эмб-ын тусгай зөвшөөрөлд нэмэлт өөрчлөлт оруулж, 4 эмийн сангийн тз-ийн эрхийг хүчингүй болгож, 8 эмийн сангийн тз-ийн эрхийг 3 сараар түр түдгэлзүүлж, 6 эмийн сангийн эрхийг сэргээв. | 100% |
| Стратеги төлөвлөгөөний зорилго 9. Сувилахуй, эх барихуйн асуудлаарх дэлхийн стратегийн чиглэл, 2021-2025 бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах зорилтын хүрээнд | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9.1 | Сувилахуйн зөвөлгөө өгөх цэг байгуулах | 3 сая | Байгуулагдсан төвийн тоо, тушаал, | 0 | 1 | Өдрийн сувилахуйн төв, сувилагчийн зөвлөгөө өгөх төвийн удирдамжийн дагуу аймгийн нэгдсэн эмнэлэгт өдрийн эмчилгээний хэсэгт 1 сувилагч орон тоогоор ажиллаж байгаа ба өдрийн эмчилгээ, асаргаа сувилгааны талаар зөвөлгөө өгч байна. 2023 оны байдлаар 387 хүнд өдрийн эмчилгээ хийж, асаргаа сувилгаа, сувилахуйн тусламжийн талаар зөвлөгөө өгсөн байна. Сувилахуйн хэсэг тусдаа байгуулагдаагүй. ЭМСайдын 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн Журам батлах тухай А/381 дүгээр тушаалаар батлагдсан Сувилахуйн дагнасан тусламж, үйлчилгээг үзүүлэх төвийн үйл ажиллагааны талаарх санал, тусламж үйлчилгээний жагсаалтын саналыг ЭМЯ-д хүргүүлсэн. | 100% |
| 9.1.2 | Сувилахуйн тусламж, үйлчилгээнд чанар сайжруулах үйл ажиллагаа зохион байгуулах | | Зохион байгуулсан үйл ажиллагаа ны тоо, сэдэв | 70% | 90% | Ахлах сувилагч нарт сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж нийт 21 сувилагчийг хамруулсан ба 2023 онд хийх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулсан.<br>-Монголын сувилагчдын нийгэмлэгтэй хамтран аймгийн хэмжээнд “Сувилагчаа сонсьёо” хэлэлцүүлэг зохион байгуулж нийт 200 гаруй сувилагчийг хамруулсан.<br>-“БИДНИЙ СУВИЛАГЧ– БИДНИЙ ИРЭЭДҮЙ” сувилагчийн “НЭГ ӨДӨР” аян зохион байгуулж, АНЭ-ийн сувилагч нар төр болон төрийн бус байгууллага, өрх, сумын эрүүл мэндийн төвүүд өөрийн харьяа эмзэг бүлгийн болон нийгмийн тодорхой зорилтот бүлгийн өрхүүдэд очиж эмчийн үзлэг, оношлогоо, эмчилгээ, асаргаа сувилгаа хийж давхардсан тоогоор 2321 хүн хамруулж сувилахуйн тусламж, үйлчилгээ үзүүлэн 12 төрлийн санамж тараасан байна.<br>-Бүх шатны эрүүл мэндийн байгууллагууд сувилагч, эх баригч мэргэжлийг сурталчлах, олон нийтийн мэдээлэл суваг, ТВ –ээр нэвтрүүлэг хийж, ярилцлага зохион байгуулсан.<br>-Аймгийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн яаралтай тусламжийн бэлэн байдал, хүүхдэд үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээний | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэлэн байдал, судасны гуурсны тандалт, хэрэгжилтэнд 2 удаагийн хяналт үнэлгээ хийсэн. Нийт 53 хүүхдэд тавигдсан уян зүүний бэхэлгээ, давхардсан тоогоор 2941 хүүхдийн уян зүүний тандалтын хуудсыг хянаж илэрсэн алдаа дутагдалыг газар дээр нь засаж, зөвлөмжөөр хангасан.<br>-Үр дүн: Уян зүүнд хэрэглэгдэх ариун шарик нь ариутгасан, вакумдсан, бага савлагдсан хэлбэрээр хангадсан<br>-Хүүхдийн тасгийг ариун бээлийгээр хангасан<br>-Уян зүүний тандалтын хуудасын хөтлөлт сайжирсан<br>-Уян зүүний зориулалтын наалт хэрэглэж хэвшсэн<br>-Цус тээвэрлэх савтай болсон<br>-Зүрх судасны өвчтэй хүнд үзүүлэх сувилахуйн тусламжийн хяналтын хуудасаар 2023 оны байдлаар зүрх судасны өвчтэй 47 хүнд, амьсгалын замын өвчтэй 93 хүнд төрөлжүүлэн сувилахуйн тусламжийг үзүүлж, хяналтын хуудсын хэрэгжилт 75% тай байна.<br>-АНЭ-ийн төрөх тасгийн нярайн хэсэгт бага жинтэй нярайг “ИМЖ ЭХ”-ийн аргаар дулаацуулах зааварыг боловсруулж өгсөн. 2023 оны байдлаар 21 нярайд имж эхийн аргыг хэрэгжүүлсэн. Хэрэгжилтийн хувь 46% тай байна.<br>-Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын ахлах сувилагч нарт “Сувилагчийн ээлж хүлээлцэх журам”, “Амин үзүүлэлтийн ажилбар”, “Асаргаа сувилгааны ажилбар” чеклист боловсруулан арга зүйгээр хангасан.<br>-“Бөөрний архаг дутагдал өвчний үед үзүүлэх сувилахуйн тусламж”, “Пиелонефрит өвчний сувилахуйн тусламж”, “Анхдагч даралт ихсэх өвчний сувилахуйн тусламж”, “Элэгний хатуурлын үеийн сувилахуйн тусламж”-ийн удирдамжууд.<br>-“Дутуу нярай хүүхдэд үзүүлэх сувилахуйн тусламж, үйлчилгээний заавар”.<br>-“Braden-ий үнэлгээний хяналтын хуудас, хэвтрийн цооролт үүсэх эрсдлийг үнэлэх, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | braden-ий хүснэгт”.<br>-“E-health программын сувилахуйн түүхийг хянах шалгуур үзүүлэлт”. “Катетрийн халдваргүйтэлийн хяналтын хуудас” “Монитрын аппаратны үйл ажиллагааны хяналтын хуудас”-уудыг тус тус боловсруулан харьяа байгууллагуудын ахлах сувилагч нарыг арга зүйгээр хангасан. 100%<br>Сувилахуй тусгай мэргэжилтнүүдийн стандартын хэрэгжилтийн үнэлгээ бүтэн жилийн байдлаар 80,1% ба өмнөх онтой харьцуулахад 2,3%-аар өссөн үзүүлэлттэй байна. Анхан шатны бичиг баримтын ИМҮ-ний хэрэгжилт 69%-тай. Мөн аймгийн НЭ-ийн чанар аюулгүй байдлын чиглэлээл хяналт үнэлгээ хийж зөвлөмж өгч ажилласан зөвлөмжийн биеэлэлт 75%-тай байна . | |
| Стратеги төлөвлөгөөний зорилго 10. МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, яаралтай, гамшгийн үеийн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг сурталчлан таниулах, Бусад эрх зүйн баримтуудыг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах” зорилтын хүрээнд | | | | | | | |
| 10.1 | Арга хэмжээ №2.1. Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулах сургалт зохион байгуулж, техник, тоног төхөөрөмжөөр хангана. | 60 сая | Шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтын хувь,<br>Ажлын байрны таатай, эрүүл, аюулгүй байдлыг хангасан байгууллагын тоо | 1 | 6 | Яаралтай тусламжийн цогц менежмент гэсэн сэдвээр багц цагийн сургалт зохион байгуулах гэж бэлтгэл үйл ажиллагаа хийж байгаа. Аймгийн нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн тасгийн Эмч Н.Тилеухавал дүрс оношилгооны мэргэжлээ, сувилагч А.Бахытгүл Яаралтай тусламжийн сувилахуйн курс төгссөн.<br>Эрүүл мэндийн даргын 51-р тушаалаар бүх сумын эрүүл мэндийн төвүүдэд яаралтай тусламжийн эмчийн орон тоо баталсан ба мэргэшүүлэх сургалтад эмчээ бэлтгэн явуулж байна.<br>2023 оны 1-р сард мэргэжил дээшлүүлэх сургалтад яаралтай тусламжаар 3 сумын эмч, 4 багийн эмч нарын захиалгыг өгч, баталгаажсан ба хавар элсүүлэхээр ажиллаж байгаа. | 100% |
| 10.1.1 | Яаралтай тусламжийн бэлэн байдал хангагдсан жишиг сумын эрүүл мэндийн төв бэлдэх | 300 сая | Жишиг сумын эрүүл мэндийн төвийн тоо | 0 | 3 | ЭМГазрын даргын албан тоотоор Аймгийн Засаг Даргад Толбо сумын ЭМТ, Улаанхус сумын ЭМТ, Цагааннуур тосгоны ЭМТөвд яаралтай тусламжийн цэг байгуулахад нийт шаардагдах санхүүжилт 294.241.000 төгрөг | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүхий төслийг оруулсан боловч санхүүжилт шийдвэрлэгдээгүй. | |
| Стратеги төлөвлөгөөний зорилго 11. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬ", "ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ", "ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ",ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ТӨЛӨВЛӨХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТАЙЛАГНАХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 11.1 | НЭ, сум дундын эмнэлэг, сум тосгоны ЭМТ-үүд болон Хувийн эмийн сангууд, ЭХНБ-уудад MNS:2015 5260 стандартын хэрэгжилт, эмийг жороор олголтын байдал, "Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль" болон бусад хууль тогтоомжуудын хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж, зөвлөмж хүргүүлэх. | | Боловсрул сан удирдамж ийн тоо, хяналт үнэлгээ хийсэн эмийн сангийн тоо | 2 удаа | 2 удаа | Эрүүл мэндийн тухай хуулийн 12.1.4 дахь заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 6.1 дугаар зүйлийн 1.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, 10.4, 11.1.2 зэрэг заалтууд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан холбогдох тушаал, журам, "Эмийн санд тавих нийтлэг шаардлага" MNS 5260:2015 стандартын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн 50 эмийн санд төлөвлөгөөт хяналт үнэлгээ хийж, зөвлөмжөөр хангасан. Их эрсдэлтэй үнэлэгдсэн 10 эмийн сангийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх саналаа Тусгай зөвшөөрөл олгох комисст хүргүүлсэн бөгөөд 5 эмийн сангийн тусгай зөвшөөрөл хүчингүй болгосон. | 100% |
| 11.1.1 | Сумдын эмийн эргэлтийн санг Эрүүл мэндийн сайдын 2009 оны 297 дугаар тушаалын дагуу зохион байгуулалтад оруулан хяналт тавих, иргэдийг чанартай, хөнгөлөлттэй эмээр хангагдах нөхцөлийг бүрдүүлэх | | Эмийн эргэлтийн сан ажиллуулах журам | 1удаа | 1удаа | Төрөөс эмийн талаар баримтлах бодлого, холбогдох хууль журмын дагуу сумдад үйл ажиллагаа явуулж байгаа эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаанд "Эмийн санд тавих нийтлэг шаардлага MNS 5260:2015" стандартын хэрэгжилт болон Эрүүл мэндийн сайдын 2011 оны 297 дугаар тушаал "Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам"- ыг үндэслэн үнэлгээ хийсэн. Эрүүл мэндийн газрын даргын 684 тоот албан бичгээр эмийн эргэлтийн санг тусгай зөвшөөрөлтэй болгож, түүний үйл ажиллагаанд хяналт тавих Засаг даргын дэргэдэх удирдах зөвлөл байгуулан ажиллах талаар зөвлөмж хүргүүлсэн боловч биелэлт хангалтгүй байна. Цаашид эмийн эргэлтийн санг ямар статусаар ажиллах талаар сумдын удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн гаргасан санал, 2022 он болон 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан, үлдэгдэл эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн мэдээ гаргаж аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахаар ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Одоогийн байдлаар Сагсай, Цэнгэл, Цагааннуур зэрэг сумдад эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагаа хэвийн явагдаж, сумын иргэдэд эм зүйн тусламж үйлчилгээг үзүүлж байна. | |
| Стратеги төлөвлөгөөний зорилго 12. Харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тусгайлсан хяналт үнэлгээ, дотоод аудит хийж, шийдвэр гаргагчдыг мэдээллээр цаг тухайд хангах | | | | | | | |
| 12.1 | Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/605 дугаар тушаалын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2021 оны А/751 дүгээр захирамжийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд | 5.0 сая | Хийгдсэн хяналт үнэлгээ, дотоод аудитын тоо | 27 | 30 | Тайлант онд Эрүүл мэндийн газраас харьяа эрүүл мэндийн байгууллагуудад нийт 40 удаагийн тусгайлсан хяналт үнэлгээ зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 70 байгууллагад очиж ажиллаж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллалаа. Хийгдсэн хяналт үнэлгээ бүрийн багийн зөвлөмжийг албан бичгээр тухайн байгууллагад хүргүүлж, даргаагийн хяналт үнэлгээгээр хэрэгжилтийг хянасан.<br>Мөн улсаас төсөв авч үйл ажиллагаа явуулж байгаа АНЭ, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд 1-4 удаагийн дотоод аудит хийгдэж, зөвлөмжөөр хангасан | 100% |
| 12.1.1 | Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх аргачлалын дагуу харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тусгайлсан хяналт-шинжилгээ, үнэлгээний хийх ажлыг зохион байгуулах, хяналт тавих | 4.0 сая | Хийгдсэн хяналт үнэлгээний тоо | 27 | 30 | Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийх нийтлэг аргачлал” дагуу тус оны эхний хагас жилийн байдлаар Эрүүл мэндийн газраас харьяа эрүүл мэндийн байгууллагуудад нийт 40 удаагийн хяналт үнэлгээ зохион байгуулагдаж, давхардсан тоогоор 75 байгууллагыг хамруулсан байна. Үүнд:Эх, хүүхдийн идэвхтэй хяналт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, магадлан итгэмжлэлд орох харьяа байгууллагуудад явцын үнэлгээ, эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийн явц, статистик мэдээлэл, шинээр тусгай зөвшөөрөл хүсэгч байгууллагуудын орон байрыг үнэлэх, өргөдлийн мөрөөр болон хаваржилт хүндэрсэн сумдад хяналт үнэлгээ, өрхийн эрүүл мэндийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төвүүдийн үйл ажиллагааг гурвалсан гэрээний дагуу хагас, бүтэн жилээр дүгнэх хяналт үнэлгээнүүд хийгдэж, мэргэжил арга зүйгээр хангаж, зөвлөмжүүд хүргүүлж ажиллалаа. | |
| 12.1.2. | Эрүүл мэндийн газрын болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, зөвлөмж хүргүүлж, дүгнэлтийг удирдлагад танилцуулах | 1.0 сая | 1.2 | 3 | 6 | Эрүүл мэндийн даргын баталсан удирдамжаар АНЭ-д 2 удаа, 12 сумуудад нэг удаа, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нэг удаа тус тус очиж санхүүгийн бэрхшээлд орох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор харьяа эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил, арга зүйгээр хангах, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, санхүүгийн үйл ажиллагаанд нь мөрдөн ажиллах шинэчлэгдсэн эрх зүйн актуудыг танилцуулан, мэргэжил арга зүйгээр хангаж, зөвлөмж хүргүүлэн ажилласан.<br>Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 05 тоот тогтоолын 3 дугаар зүйлийн 3.12 дахь заалтын дагуу баталсан “Сум, тосгоны эрүүл мэндийн төв”-д ажиллах хүний нөөцийн доод хязгаарыг батлах тухай” аймгийн Эрүүл мэндийн газрын даргын А/51 дүгээр тушаалын биелэлтэд тогтмол хяналт тавьж, Хөдөлмөрийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2018 оны 382, 2019 оны 05, 33, 2023 оны 240, 241 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/548 тоот тушаал, 2019 оны 611 тоот тушаал, стандарт зэрэг холбогдох эрх зүйн актуудыг мөрдөн ажиллаж, төсвийн сахилга батыг чанд сахиж, батлагдсан орон тооны дэд хязгаарт багтаан, тэтгэвэрт гарсан хүний оронд шинээр хүн нэмж авахгүй байж, тэвчиж болох зардлуудаа хэмнэн төлөвлөгөө боловсруулан ажиллахыг зөвлөн ажиллаж байна. | 100% |
| 12.1.3 | Шилэн дансны тухайн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 заалтыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд | 0.1 сая | Шилэн дансны хуулийн хэрэгжилт | 100% | 100% | Харьяа эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн ил тод байдлыг хангуулах зорилгоор харьяа эрүүл мэндийн байгууллагуудын шилэн дансны хөтлөлтөд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ийн хувь | | | буюу цаг тухайд нь хууль журмын дагуу байршуулсан эсэхэд байнга хяналт тавьж ажиллаж байна. Харьяа байгууллагуудад шилэн дансны хөтлөлтийг хугацаандаа оруулж хэвших талаар албан бичиг хүргүүлэн арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Сар болгоны эхэнд харьяа эрүүл мэндийн байгууллагуудын нягтлан бодогч нарт утсаар болон цахимаар сануулан, албан бичгээр шилэн данс хөтлөх талаар зааварласан. Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн, ойлгомжтой, ач холбогдолтой, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг, хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх гэсэн зарчмуудыг үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлэн, цаашид зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө гарган ажиллах талаар зөвлөмж хүргүүлсэн. | |
| 12.1.4 | Харьяа байгууллагуудын шилэн дансны хөтлөлтөнд хяналт тавих | 0.1 сая | Шилэн дансны хуулийн хэрэгжилт ийн хувь | 100% | 100% | | |
| 12.1.5 | Эрүүл мэндийн сайдын 2013 оны 140 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд | 10.0 сая | Цахим хуудасны хөтлөлт, цахимд шилжсэн үйл ажиллагаа | 60% | 70% | ЭМС-ын 2014 оны 140 тоот тушаалын дагуу харьяа байгууллагуудын үйл ажилгааг зохицуулах хэрэгжилтийг хангаж ажилладаг. ЭМГ-ын үйл ажиллагааг www.health.bo.gov.mn цахим хуудас, Баян-Өлгий Эрүүл Мэндийн Газар нэртэй сошиал файсбуук хаягаар олон нийтийг эрүүл мэндийн мэдээ мэдээлэлээр хангах зорилгоор тогтмол шинэчлэн хөтлөн эрүүл мэндийн талаар мэдээ мэдээлэлийг олон нийтэд хүргэж ажилладаг. Цахимд шилжих үйл ажиллагааны хүрээнд эмнэлэгийн цаг захиалгын 1800-0119 тусгай дугаар, онлайн цаг захиаалах үйлчилгээ e-mongolia.mn сайтаар захиалан авдаг болсон. | 100% |
| 12.1.6 | Мэдээллийн технологийг боловсронгуй болгож, цахим эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлэх | 10.0 сая | Цахим хуудасны хөтлөлт, цахимд шилжсэн үйл ажиллагаа | 60% | 70% | ЭМС-ын 2014 оны 140 тоот тушаалын хүрээнд харьяа байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах интернэт сүлжээг шилэн кабелд шилжүүлж, байгууллагын Цахим хуудас болох www.health.bo.gov.mn веб сайт тогтмол хөтөлж Цахим эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлэх Нэгдсэн эмнэлгийн амбулатори, лаборатори, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дэмжих төвийн үйл ажиллагаанд цахимаар цаг олгож, аль болох чирэгдэлгүй үйлчилгээ авах нөхцөл боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад цахим системээр цаг товлож, шинжилгээний хариуг цахимаар e-mongolia.mn сайтаар авч, иргэд цаг хугацаагаа хэмнэж байна. | |
| 12.1.7 | Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх | 1.0 сая | Мэдээний чанар, боловсруулсан мэдээллийн тоо | 15 | 15 | 2023 онд ЭМС-ын 2019 оны 611 дүгээр тушаалын хавсралтын АМ-36 дугаар маягтын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээий өдрийн мэдээг нийт 224 удаа бүх нэгжүүдээс авч нэгтгэн burtgel.mohs.mn программаар авч эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээлэв. 7 хоног бүр Нэгдсэн эмнэлэг, өрх, сумын эрүүл мэндийн төвүүдээс эхийн төрөлт, хүүхдийн нас баралт, төрөлхийн гажиг, жирэмслэлттэй холбоотой мэдээллүүдийг google sheet ашиглан нэгтгэн авч долоо хоног болгоны 3-дахь өдөр ЭХЭМҮТ-ийн тандалтын албанд тогмол мэдээлэн ажиллаж байна. Хүн амын төрөлт нас баралт, өвчлөл, сарын мэдээг ЭМТ-501 маягтын дагуу сар болгоны сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа сарын 4-ний өдөр хүртэл бүх харьяа байгууллагуудаас нэгтгэн авч Эрүүл мэндийн хөгжлийн төвд нийт 12 удаа сарын мэдээ явуулав. ЭМГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу улсын байцаагч, мэргэжилтэнүүдтэй хамтран Нэгдсэн эмнэлэг, 4 өрхийн эмнэлэгт ЭМС-ын 2019 оны А/611 дүгээр тушаалын дагуу анхан шатны маягтуудын хөтлөлт, хадаглалт мэдээнийн үнэн бодит мэдээллэх чанарт хяналт үнэлгээ хийж, илэрсэн зөрчилийг тухай бүрт арилган заавар зөвлөмж өгч ажиллав. | 100% |
| 12.1.8 | Статистик тоо мэдээллийн үнэн бодит байдлыг хангаж, шийдвэр гаргагчдыг цаг тухайд нь мэдээллээр хангах | 1.0 сая | Мэдээний чанар, боловсруулсан мэдээллийн тоо | 15 | 15 | Тайлангийн жилд нийт 12 удаа сарын мэдээ гаргаж, статистик тоо мэдээллийг анхан шатны маягттай тулгаж, мэдээний үнэн бодит байдлыг хангасан. Нийт 12 удаа 6 хуудас бүхий сарын мэдээг өмнөх онтой харьцуулсан байдлаар гаргаж, аймгийн ЗДТГ-ын НБХ, Статистикийн хэлтэс, Эрүүл мэндийн газрын дарга, хэлтсийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дарга болон мэргэжилтнүүдэд тухай бүрт шаардлагатай мэдээллээр ханган ажиллаж байна. Харьяа байгууллагуудын статистик мэдээллийн үнэн бодит байдлыг хангах зорилгоор 4 удаа эргэн мэдээлэл бэлтгэж хүргүүлсэн. ЭМСайдын 2022 оны 139 дүгээр тушаалын дагуу урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ оношилгооны статистик тоо мэдээнүүдийг аксис программын мэдээний баазыг ашиглан 7 хоног болгон харьяа эрүүл мэндийн байгууллга, өрх сумаар нь гаргаж, шийдвэр гаргагчдыг нийт 46 удаа мэдээллээр хангасан. | |
| Стратеги төлөвлөгөөний зорилго 13. "Эрүүл мэндийн хүний нөөцийн бодлого боловсруулах,төлөвлөх хөгжүүлэх, сургалтанд хамруулах менежментийг боловсронгуй болгох, ажилтануудыг зөв хувиарлах, хууль эрх зүйн хүрээнд ажиллах" | | | | | | | |
| 13.1 Зорилт. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд хүний нөөцийн бодлоыг оновчтой зохион байгуулах, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг чадварыг дээшүүлэх зорилтын хүрээнд: | | 30 сая | Чадавхжуулах сургалтад хамрагдсан хүний тоо | | | 2023-2024 оны хичээлийн жилд төсвийн зардал болон орон нутгийн зардлаар суралцах эмч, мэргэжилтнүүдийн захиалгыг салбар нэгжүүдээс авч хүний нөөцийн төлөвлөгөөний дагуу Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлсэн<br>Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан суралцагчдын тоон мэдээллийг салбар нэгжүүдэд хүргүүлэн, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.<br>Аймгийн Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа Хүний нөөцийн одоогийн байдалд дүн шинжилгээ хийж мэргэжилтнүүдийн мэргэшсэн байдлын судалгааг гаргасан. Сум , тосгон ,өрхийн эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлэгт ажиллаж байгаа 80 их эмчийн 54% буюу 43, 135 сувилагчийн 30% буюу 42 нь төгсөлтийн дараах мэргэшил олгох, дээшлүүлэх сургалтанд хамрагдсан бол Нэгдсэн эмнэлэгт ажиллаж байгаа эмч нарын 97 буюу 90,5%, сувилагчдын 75 буюу 50 % нь нарийн мэргэжилийн сургалтанд хамрагдсан тухай судалгаа гарч түүний дагуу хүний нөөцийн төлвөлөлийг хийгдсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 13.1.1 | Аймгийн Эрүүл мэндийн салбарын ажиллагсдын дотоодын болон багц цагийн сургалт, зайны сургалтад эмнэлгийн мэргэжилтнүүдийг тасралтгүй хамруулах ажлыг зохион байгуулах | - | Сургалтад хамрагдан багц цагийг биелүүлсэн эмнэлгийн мэргэжилтний тоо | 80% | 90% | Улсын төв эмнэлгүүд болон сургалт эрхлэгч байгууллагуудаас зохион байгуулагдсан цахим сургалт, зөвлөгөөн уулзалтад тухай бүр холбогдох эмч мэргэжилтнүүдийг хамруулан ажилласан. Эмч, мэргэжилтнүүд HRDS (hdc.gov.mn) программаар хүсэлт илгээж, багц цагийн сургалтанд хамрагдаж, биелүүлвэл зохих багц цагийг бүрдүүлсэн. Эрүүл мэндийн яам, Улсын төв эмнэлгүүд болон сургалт эрхлэгч байгууллагуудаас зохион байгуулагдсан цахим сургалт, зөвлөгөөн уулзалтад тухай бүр холбогдох эмч мэргэжилтнүүдийг хамруулан ажилласан.<br>Эрүүл мэндийн яам, сургалт эрхлэгч байгууллагууд бусад төсөл хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдсан ажлын байрны сургалтад холбогдох мэргэжилтнүүдийг үе шаттай хамруулан ажилласан. | 100% |
| 13.1.2 | Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг гадаад, дотоодод туршлага судлуулан мэргэшүүлэх, урт богино хугацааны сургалтад хамруулж, чадавхжуулах | 10 сая | сургалтад хамрагдсан эрүүл мэндийн ажилтны хүний тоо | 25 | 28 | Аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн төлөвлөлтийн дагуу салбар нэгжүүдээс 2023-2024 онд улсын төсвийн санхүүжилтээр, байгууллагын зардлаар суралцуулах эмч, эмнэлгийн мэргэжилтний захиалгыг хийж, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/103 дугаар тушаалаар батлагдсан хязгаарын дагуу эмч мэргэжилтнүүдийг улсын төсвийн санхүүжилтээр суралцуулж байна. Тайлангийн жилд үндсэн мэргэшлийн сургалтад Дотрын анагаах судлал 3, Эх барих эмэгтэйчүүд судлал 1, Хүүхэд судлал 2, Сэргээн засал судлалаар 1, яаралтай тусламж судлалаар 2, Зүү эмчилгээ судлал 1,нүүр амын гажиг засал 1, нүр амын мэс засал судлал 1, нуд судлал 1, дүрс оношилгоо судлал 1, мэдээгүйжүүлэлт судлал 1 нийт 15 эмчийг үндсэн мэргэшлээр, төрөлжсөн мэргэшлийн 6 сарын сургалтад 8 их эмч, мэргэжил дээшлүүлэх сургалтад 5 эмчийг хамруулсан бол сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтний 3 сарын төрөлжсөн мэргэшлийн сургалтад 34 мэргэжилтэнг, дээшлүүлэх сургалтад 3 сувилагчийг тус тус хамруулан ажилласан.<br>ХШҮМХэлтсийн даргыг ДЭМБайгууллагын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Номхон Далайн Баруун Бүсийн Олон улсын эрүүл мэндийн сургалтын төвөөс жил бүр зохион байгуулдаг 2 модуль бүхий /цахим болон танхимын/ тэтгэлэгт хөтөлбөр"-ийн сургалтад Филиппин улсын Манила хотод, төрөх тасгийн Эх барих эмэгтэйчүүдийн 1, нярайн 1 эмчийг ОХУлса , хүүхдийн тасгийн 1 сувилагч БНХАУ-ын хөх хотод богино хугацааны сургалтад тус тус хамрагдсан. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын 3 сувилагч, нэгдсэн эмнэлгээс 1 эх баригчийг ДЭМБ-ын санхүүжилтээр гадаадад богино хугацааны сургалтад хамруулсан бол, 3 багийн бага эмчийг БНХАУ-ын Хөх хотод богино хугацааны сургалтад хамрагдсан. | |
| 13.1.3 | Аймгийн Нэгдсэн эмнэлэг болон сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд шаардлагатай үндсэн нарийн мэргэжлийн эмч нарыг бэлтгэх, тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэн, нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх | 20 сая | Төгсөлтийн дараах сургалтанд хамрагдсан эмч мэргэжилтний тоо | 93% | 95% | 2023 онд Ногооннуур сумын Эх барих эмэгтэйчүүдийн судлалын эмчээр, Алтанцөгц Бугат сумын ЭМТөвийг хүүхдийн эмчээр, Булган сумын эрүүл мэндийг дотрын эмчээр, Цэнгэл сумын ЭМТөвийг яаралтай тусламжийн эмчээр, Аймгийн Нэгдсэн эмнэлэг Мэс заслын 1, Эмнэлзүйн эмгэг судлалын 1, Анатомийн эмгэг судлалын 1, Дотрын анагаах судлалын 3 эмчээр, мэдрэл судлалын 1, мэдээгүйжүүлэлтийн 1 эмчээр тус тус хангасан. Үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтад эмч мэргэжилтнүүдийг тогтмол хамруулан эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллаж байна. | 100% |
| 13.1.4 | Эрүүл мэндийн салбарын албан хаагчид, суманд ажиллахаар очсон эмч, мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулахад дэмжлэг үзүүлэх, багийн эмч нарын ажиллах орчин нөхцлийг сайжруулж, шаардлагатай эмнэлгийн хэрэгслээр хангах | - | Суманд ажиллах албан хаагчдын тоо | 9 | 10 | Эрүүл мэндийн салбарын хэмжээнд Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол 2022 оны 488, 489, 2023 оны 240,241 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллага бүр ажилтнуудын цалинг тогтоолын дагуу шинэчлэн тогтоосон.<br>-Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу Эрүүл мэндийн байгууллагууд Хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээг шинэчлэн боловсруулан ажилтны нийгмийн баталгааны чиглэлээр тодорхой заалтуудыг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эрүүл мэндийн тухай хуулийн 29.5 дугаар заалтаар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зүйлийн дагуу 170 эмнэлгийн мэргэжилтэнд 676,143,366 төгрөг, 29.2 заалтаар 65 эмнэлгийн мэргэжилтэнд 1,396,127,125 сая төгрөг олгогдсон. Эрүүл мэндийн байгууллага бүр ажилтнуудаа урьдчилан<br>сэргийлэх үзлэгт хамруулсан ажилласан нийт эрүүл мэндийн ажилтнуудын 85 % хамрагдсан. -Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтнүүд байгууллагын албан хаагчдад хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалтыг жилд 1-2 удаа зохион байгуулж, албан хаагчдыг хөдөлмөр хамгааллын хувцсаар ханган ажилласан. Хөдөө сумдад ажиллаж байгаа зарим эмч нарыг орон нутгаас нь орон байраар ханган ажиллаж байна. Үүнд: Ногооннуур сумын сум дундын эмнэлгийн 1, Цагааннуур тосгоны эрүүл мэндийн төвд 2 эмнэлгийн мэргэжилтэн, Алтанцөгц сумын 1 багийн бага эмчийг, Булган, Улаанхус, Толбо сумын ЭМТөвүүд тус бүр 1 эрүүл мэндийн ажилтанг тухайн эрүүл мэндийн харьяанд байгаа эмнэлгийн орон сууцаар хангасан. | 100% |
| 13.1.5 | Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэшлийн зэргийн шалгалтанд хамруулах ажлыг зохион байгуулах | - | Мэргэжлийн зэрэг шинээр хамгаалсан эмч, мэргэжилтний тоо | 9 | 15 | Мэргэшлийн зэрэгтэй холбоотой гарсан тушаал шийдвэр, холбогдох мэдээллийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлэн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэдээллээр ханган ажилласан. Мэргэшлийн зэрэг горилох эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн материалын бүрдүүлэлтэд хяналт тавьж, Мэргэшлийн зэрэг горилох шалгалтад орох мэргэжилтнүүдэд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Тайлангийн жилд 5 эмч, 20 гаруй сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн мэргэжлийн зэрэг хамгаалсан болно. | 100% |
| Стратеги төлөвлөгөөний зорилго 14. Аймгийн эрүүл мэндийн салбарыг орчин үеийн стандартад нийцсэн шинэ барилга, тоног төхөөрөмж, автотээврийн хэрэгсэлээр хангах | | | | | | | |
| Хөрөнгө оруулалт | | | | | | | |
| 14.1 | Аймгийн НЭ-гийг үргэлжлүүлэн барих | Нийт 28,6562 тэрбум 2023 онд 5,7654 тэрбум | Үйл ажиллагааны хэрэгжилт хувиар | 50% | . Шинэ байртай болно | **Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар:** Аймгийн Нэгдсэн эмнэлэг шинээр баригдаж байгаа. Төсөвт өртөг нь 28,656,2 тэрбум. 2023онд батлагдсан төсөв нь 5,765,4 тэрбум төг. 2025 онд ашиглалтанд орно. | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14.1.2 | ЭМГ-ын эмийн агуулах | 400,0 сая | Ажлын гүйцэтгэл ийн хувь | 0 | Шинэ байртай болно. | Ногооннуур сумын Ховд багт 5 ортой ЭМТөв 416,7 сая төгрөгөөр баригдаж байгаа. 2025 онд ашиглалтанд орно. Улаанхус сумын ЭМТөвд 428,7 сая төгрөгийн өргөтгөл хийгдсэн. Улсын комисс хүлээж авсан. | 70% |
| 14.1.3 | Ногооннуур сумын Ховд багийн ЭМТөвийг үргэлжлүүлэн барих | Нийт 416,7 сая 2023 онд 76,7 сая | Ажлын гүйцэтгэл ийн хувь | 70% | Шинэ байртай болно | 2023 онд ашиглалтанд орсон.Улсын комисс хүлээж авсан. Нийт 427,8 сая төгрөгийн барилгын өргөтгөл хийгдэсэн. | 100% |
| 14.1.4 | Улаанхус сумын ЭМТөвийн өргөтгөл | Нийт 428,7 сая 2023 онд 84,9 сая | Ажлын гүйцэтгэл ийн хувь | 70% | | Үргэлжлэн баригдаж байгаа.2024 онд ашиглалтанд орно. | 30% |
| 14.1.5 | Өлгий сумын Хотгор багийн ЭМТөвийг үргэлжлүүлэн барих | Нийт 1 903,0 сая 2023 онд 50,0 сая | Ажлын гүйцэтгэл ийн хувь | 50% | Шинэ байртай болно | Ногооннуур сумын ЭМТөвийн барилгад 30сая | 100% |
| 14.1.6 | Ногооннуур сумын ЭМТөвийн засварын ажил | 30,0 сая | Ажлын гүйцэтгэл ийн хувь | | | Улаанхус сумын Хөх хөтөл багын эрүүл мэндийн төвийн барилгад 40 сая төгрөгийн засварын ажил хийгдэж улсын комисс хүлээж авсан. | 100% |
| 14.1.7 | Улаанхус сумын Хөх хөтөл багийн ЭМТөвийн засвар | Нийт 120,0 сая 2023 онд 70 сая | Ажлын гүйцэтгэл ийн хувь | | | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаарАймгийн НЭ бүрэн тоноглогдсон түргэний автомашинаар хангагдсан. Үнэ нь 180,0 сая төг.<br>ОНХС-аас Булган сумын 7 дугаар багийн бага эмчийг мотоциклээр хангасан. Үнэ нь 3,0 сая төг | |
| 14.1.8 | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт бүрэн тоноглогдсон түргэний машин ,ЭМГ, Сагсай, Толбо ЭМТ, ЗӨСТ,4 өрхийн ЭМТ-ийг шинэ автомашинтай болгох | 360,0 сая | Түргэний машины тоогоор | | Ард иргэдэд түргэн шуурхай үйлчлэх | **Нэгдсэн эмнэлэг:**<br>**Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар**Хүүхдийн даралт хянах аппарат, Үзлэгийн хажуугийн гэрэл,Судас тодруулагч, Хүүхдийн биеийн дулаан хэмжигч цаг, Нярайн эмнэлгийн ор (пластик), Хүүхдийн яралтай тусламжийн тэргэнцэр, Амьсгал тоологч,Хүүхэд ба нярайн зүрхний бичлэгийн аппарат, Амьсгал тоологч, Хүүхдийн нүдний дуран, Хүүхдийн чихний дуран,Дуслын тарианы автомат шахуурга, Тариурын автомат шахуурга, Өвчтөний монитор, Нярайн амбу, Дефиблиррятор,Зөөврийн ЭХОзэрэг 18 нэр төрлийн 61,8 сая төгрөгийн өртөгтэй тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.<br><br>**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар** 75,4 сая төгрөгийн өртөгтэй Нүдний набор, Хагалгааны таазны гэрэл, Elisa | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | уншигч, Elisa угаагч, Инкубатор сэгсрэгч аппаратуудаар хангагдсан.<br>**Сумдын эрүүл мэндийн төвүүдийн хувьд:**<br>Дэлхийн банкны санхүүжилтээр КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах, төслийн хүрээнд 12 сум, 1 тосгоны ЭМТөв 73,8 сая төгрөгийн өртөгтэй ариутгалын автоклаваар хангагдсан.<br>Япон Улсын Засгийн газраас Монгол улсын Засгийн Газарт "КОВИД-19 халдварт цар тахлын хямралыг арилгахад яралтай тусламж үзүүлэх хөтөлбөр"-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд Алтай, Алтанцөгц, Баяннуур, Бугат, Булган,Буянт, Сагсай, Толбо сумууд болон Цагааннуур тосгоны ЭМТөвүүдэд 120,7 сая төгрөгийн өртөгтэй спирометр болон дагалдах хэрэгслээр хангасан.<br>Глобаль сангийн дэмжлэгтэй НЭ болон бүх сумын ЭМТөвүүд хүчил төрөгчийн өтгөрүүлэгч, том хүн болон хүүхдийн хамрын гуурсаар хангадсан<br>**Орон нутгийн төсвийн хөрөнгөөр**:<br>Сагсай сумын ЭМТөв 34 сая төгрөгийн өртөгтэй эхо аппаратаар хангагдсан.<br>Ногооннуур сумын ЭМТөв 19 сая төгрөгийн өртөгтэй гал тогооны тоног төхөөрөмжөөр хангагдсан.<br>Булган сумын ЭМТөв 12 сая төгрөгийн өртөгтэй зөөврийн ЭХО, 15 сая төгрөгийн өртөгтэй шүдний тоног төхөөрөмжөөр хангагдсан.<br>Дэлүүн сумын ЭМТөв 19,5 сая төгрөгийн өртөгтэй цусны дэлгэрэнгүй шинжилгээний анализатор, болон 12 сая төгрөгийн өртөгтэй гал тогооны тоног төхөөрөмжөөр хангагдсан.<br>Цагааннуур тосгоны ЭМТөв 34,0 сая төгрөгийн өртөгтэй ЭХО аппаратаар хангагдсан.<br>**Автопарк шинэчлэлт**<br>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаарАймгийн НЭ бүрэн тоноглогдсон түргэний автомашинаар хангагдсан. Үнэ нь 180,0 сая төг.<br>ОНХС-аас Булган сумын 7 дугаар багийн бага эмчийг мотоциклээр хангасан. Үнэ нь 3,0 сая төг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| Стратеги төлөвлөгөөний зорилго 15. “ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 15.1 | Хяналт шалгалтын үйл ажиллагаа шилжсэнтэй холбоотой шинээр болон шинэчлэн боловсруулах журам, зааврын төсөлд санал боловсруулж хүргүүлэх. | Батлагдсан төсвийн хүрээнд | Боловсруулсан журмын тоо | Журмыг шинэчлэн боловсруулсан байна. | Шинээр боловсруулсан журам, дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөгө болгоно. | Монгол улсын шадар сайдын “Лабораторид дээж хүлээлгэн өгөх, лабораторид дээж хүлээн авах, шинжилгээний дүнг олгох, төлбөр барагдуулах үйл ажиллагаанд мөрдөх журам”-д 2 санал, Лабораторийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа журамд нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал ирүүлэх талаар цахимаар өгсөн чиглэлийн дагуу 2 санал хүргүүлсэн. | 100% |
| 15.2 | Хяналтын чиглэлээр шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулахад санал хүргүүлэх | Батлагдсан төсвийн хүрээнд | Хүргүүлсэн саналын тоо | Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн шинэчлэн боловсруулсан байна. | Хяналтын чиглэл бүрээр Шалгуур үзүүлэлт шинэчлэгдсэн байна | ЗГ-ын 195 тогоолоор баталсан эрсдэлийн шалгуураар шинэ обьектууддаа эрсдэлийн үнэлгээ хийсэн. | 100% |
| 15.3 | Хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулахад санал хүргүүлэх | Батлагдсан төсвийн хүрээнд | Хүргүүлсэн саналын тоо | Хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулсан байна. | Хяналтын чиглэл бүрийн холбогдох хяналтын хуудас шинэчлэгдсэн байна. | Цэцэрлэгийн эрүүл ахуй халдвар хамгааллыг шалгах хяналтын хуудсын өөрчлөлтөд 1 санал, Хог хаягдлын менежментийг шалгах хяналтын хуудасны өөрчлөлтөд 1 санал, Хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулахад 10.11.1 кодтой “Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийн эрүүл ахуйн нөхцөл шаардлагыг шалгах хяналтын хуудсанд 2 санал хүргүүлсэн. | 100% |
| 15.4 | Санал авахаар ирүүлсэн салбарын холбогдох хууль тогтоомж, стандартын төсөлд санал боловсруулах, хүргүүлэх, ажлын хэсэгт ажиллана. | Батлагдсан төсвийн хүрээнд | Санал өгсөн журам, дүрэм, стандартын тоо Хууль тогтоомж, стандартад тусгуулсан саналын хувь Ажлын хэсэгт ажилласан | Тухай бүрд нь ажлын хэсэгт ажиллаж холбогдох хууль, тогтоомжийг судлан санал өгнө. | Салбарын хууль тогтоомж боловсронгуй болно. | Эрүүл мэндийн тухай хууль-2, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд - 2, “Хүнсний үйлдвэрийн эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм”, “Үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм”-д нэмэлт өөрчлөлт оруулж боловсруулахтай холбоотой 4 санал хүргүүлсэн.<br>ЭМЯ-ны Салбарын хяналтын газраас ирүүлсэн 9/4387 дугаартай албан бичгийн мөрөөр хяналт шалгалтын явцад тулгамдаж буй, хэрэгжих боломжгүй, зөрүүтэй хууль тогтоомжийн зүйл заалтуудын талаар Эрүүл мэндийн тухай хуульд-3, эмнэлгийн тусламж | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тоо | | | үйлчилгээний тухай хуульд-3, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд-2, клиникийн бүтэц, үйл ажиллагаа стандартад-1, халдвар судлалын чиглэлээр-ЭАТХ-3, ЭМТХ-1, ЗТХ-2, холбогдох 4 стандартад-8 санал, орчны хяналтын чиглэлээр Хот суурин ус хангамж ариутгах ашиглалтын тухай хуульд-1, ТХШТХ-1, ЗГ-ын 108 тогтоолд-1, холбогдох 2 стандартад-4, хүнсний хяналтын чиглэлээр –ЭАТХ-2, холбогдох стандартад-2, хүүхдийн эрүүл ахуй хяналтын чиглэлээр-ЭАТХ-2, ТХТХ-2, ЗТХ-2, Эрүүл мэндийн сайдын 2 тушаалд-3, холбогдох 3 стандартад-3 санал хүргүүлсэн байна. | |
| 15.5 | Хяналтын обьектуудад хяналтын чиглэл бүрээр эрсдэлийн үнэлгээ хийх. | Батлагдсан төсвийн хүрээнд | Хяналтын обьектууд ын эрсдэлийг үнэлсэн байна. | 5 хяналтын чиглэлээр давхардсан тоогоор 2450 обьектод эрсдэлийн үнэлгээ хийсэн. | Салбарын эрсдэлийн бууруулсан банйа. | ЭМЯ-ны Салбарын хяналтын газраас ирүүлсэн 9/4819 дугаартай албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу 2023 онд эмчилгээ, халдвар судлал, орчин, хүүхэд, хүнсний хяналтын чиглэлээр эрсдэлийн үнэлгээ хийсэн 716 обьектоос 2024 онд 84 обьектод төлөвлөгөөт хяналт шалгалтын хийхээр төлөвлөлт хийсэн. | 100% |
| Стратеги төлөвлөгөөний зорилго 16. “ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ХИЙЖ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД | | | | | | | |
| 16.1 | Объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектуудад 5 хяналтын чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалт хийх. /Эрүүл мэнд, сургалтын байгууллага, хүнс, нийтийн үйлчилгээний зарлагдсан обьектуудад/ | Батлагд сан төсвийн хүрээнд | Шалгалт хийсэн объектын тоо, илрүүлсэн зөрчил, арилгуулал тын хувь, улсын байцаагч ийн гаргасан шийдвэр ийн биелэлт, эрсдэлийн түвшин буурсан | Тайлант хугацаанд 5 хяналтын чиглэлээр төлөвлө гөөт шалгалтанд хамрагдсан 76 объект, шалгалтын гүйцэтгэл 100%-тай байна. Хяналт шалгалтын явцад дутагдал арилгуулах | Шалгалтаар их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт объектын эрсдэлийн түвшинг бууруулсан байна. Хяналтын хуудсаар илэрсэн зөрчлийг 100% арилгуулсан байна. Торгууль, | СХГ болон ЭМГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 хяналтын чиглэлээр давхардсан тоогоор 150 байгууллага, аж ахуйн нэгжид төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн ба хүнсний хяналтын чиглэлээр-3, халдвар судлал-1, орчин эрүүл ахуйн хяналтын чиглэлээр -7, нийтдээ 11 обьект үйл ажиллагаа явуулаагүйгээс төлөвлөгөөт хяналт шалгалтанд хамрагдаагүй бөгөөд 139 обьектыг төлөвлөгөөт хяналт шалгалтанд хамааруулсан. Холбогдох хяналтын хуудсаар их-46, дунд-85, бага-8 эрсдэлтэй үнэлэгдэж, хууль тогтоомжийн хэрэгжилт-59%-тай, эрсдэл үүсэх магадлал-48%-тай байна. Хяналт шалгалтаар 3162 зөрчил илрүүлэн, 1355 зөрчлийг газар дээр нь арилгуулсан ба зөрчил арилгалт-43%- | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | объектын тоо | аар 583 заалттай 60 албан шаардлага, 76 обьектын 2452 хүнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Төлөвлөгөөт шалгалтанд хамрагдсан 76 обьектоос их эрсдэлтэй-20, дунд эрсдэлтэй-42, бага эрсдэлтэй-10 үнэлэгдсэн ба хууль тогтоомжийн хэрэгжилт 64%, эрсдэл үүсэх магадлал-42% байна. | нөхөн төлбөрийг бүрэн барагдуулсан байна. | тай.Зөрчил арилгуулах, эрсдэл бууруулахаар 1373 заалттай 107 албан шаардлагаар хугацаат үүрэг даалгавар өгч, 3 заалттай улсын байцаагчийн дүгнэлт-2, талх нарийн боовны цехийн үйл ажиллагааг түр зогсоох 2 заалттай акт үйлдсэн. | |
| 16.2 | Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчил, дутагдал, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох зорилгоор 5 хяналтын чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх. | Батлагдсан төсвийн хүрээнд | Илрүүлсэн зөрчил, арилгалтын хувь | 2022 онд 5 сэдвийн хүрээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж 623 обьектыг хамааруулс | Шалгалтаар илрүүлсэн зөрчлийг 100 хувь арилгуулсан байна. Стандартын шаардлага хангахгүй дээжийг | 1.Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газраас ирүүлсэн 10-00/27 тоот удирдамжийн дагуу аймгийн төвд нялх балчир хүүхдийн хүнс, хооллох хэрэгсэл худалдаалах үйл ажиллагаа эрхэлж буй 5 супермаркет, 3 эмийн санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын явцад 17 зөрчил илрүүлж, 12 зөрчил буюу 70%-ийг газар дээр нь арилгуулж, 2 хүнсний | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ан байна. 11 зөрчилд 4350000 төгрөгний торгууль ногдуулж барагдуулсан.52 аж ахуйн нэгж иргэнээс 79 л, 1 тн, 124 кг хүнсний бүтээгдэхүүн хурааж устгасан. Сургууль цэцэрлэгээс 60 усны дээж авч шинжилгээнд хамааруулсан. Сургууль, цэцэрлэгүүдэд ундны усны чанар, аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр зөвлөмж гаргаж хүргүүлэв. 2019 онд халдварт шар өвчин голомтлон гарсан Хөх хөтөл багийн сургуулийг гүний | шаардлагад нийцүүлнэ. | газарт 6 заалт бүхий 2 албан шаардлага хүргүүлж, 8 газарт 6 заалттай улсын байцаагчийн тарааж, 17 хүнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>2. Цагаан сар, Хүүхдийн баяр, Наадмын баярыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой 167 хүнсний худалдаа,үйлчилгээ, 2 хүнсний үйлдвэр, 126 хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар, бусад 19 нийт 314 газарт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 294 зөрчил илрүүлж, газар дээр нь 228 зөрчил буюу 77,5%-ийг арилгуулж, 8 газарт 58 заалттай хугацаат албан шаардлага хүргүүлж, 102 газарт 25 заалттай улсын байцаагчийн 3 зөвлөмж хүргүүлж, 749 ажилтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, орон нутгийн радио болон Дербез телевизээр 8 удаа мэдээлэл, сэрэмжлүүлэх, зөвлөмж өгч, байгууллагын пэйж хуудсанд 4 төрийн зурагт зөвлөмж, сэрэмжлүүлэг байршуулж, арга иргэдэд түгээж ажилласан.<br>3. Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газраас ирүүлсэн удирдамжийн дагуу нийт 10 газруудын 71 албан тушаалтан, иргэнийг урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад хамруулж, хоол хүнсэнд хэрэглэх нийтдээ 58 хүнсний бүтээгдэхүүн болон 6 ундны уснаас дээжийг лабораторид итгэмжлэлийн хүрээний дагуу 380 үзүүлэлтээр лабораторийн шинжилгээнд хамруулж, лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн 2 заалттай 1, Медиана зочид буудал, Медиана хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын орон байрны эрүүл ахуйн нөхцөлд 3 заалттай улсын байцаагчийн дүгнэлт үйлдсэн. Урьдчилан сэргийлэх хяналтаар 10 зөрчил илрүүлж, газар дээр нь 7 зөрчлийг арилгуулсан ба зөрчил арилгалт 70%-тай байна.<br>4. 03-00/21 дугаар удирдамжийн дагуу аймгийн хэмжээний хувийн ба улсын ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | худагтай болгох асуудлыг шийдвэрлүүлж уснаас дээж авч лабораторийн шинжилгээнд хамааруулсан. | | цэцэрлэгүүдийн 2023-2024 оны хичээлийн шинэ жилийн бэлтгэл үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийсэн ба 2 үе шаттай нийт 54 сургалтын байгууллага хамруулсан. Сумдын Засаг дарга нарт хичээлийн шинэ жилийн бэлтгэлийг хангуулах тухай Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 585 дугаартай албан бичиг хүргүүлсэн.<br>Сургууль, цэцэрлэгийн удирдлагуудад хичээлийн шинэ жилийн бэлтгэлийг хангуулах, Барилга хот байгуулалтын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 150/А271/А/225 тугаар тушаалын хэрэгжилтийг хангуулан ажиллах чиглэлээр ЭМГазрын даргын 2023 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 564 тоот албан бичиг хүргүүлэн ажилласан.Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын 1-р үе шатын хүрээнд бэлтгэл ажил хангагдаагүй цэцэрлэгүүдийн үйл ажиллагааг шаардлага хангуулсаны дараа үйл ажиллагааг эхлүүлэх. Цэцэрлэгийн хүүхдийн эрүүл аюулгүй орчинд сурах нөхцөл бүрдүүлэн, хоолноос шалтгаалах халдвараас сэргийлэж ажиллах талаар Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 595 тоот албан бичиг БШУГазарт хүргүүлэн ажилласан. БШУГазартай хамтран аймгийн хэмжээний ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 94 захирал, эрхлэгч нарт “Шинэ хичээлийн жилийн бэлтгэл ажилд хийсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, Үдийн хоол хөтөлбөрийн хэрэгжилт, хүнсний аюулгүй байдлыг хангуулах” талаар сургалт зохион байгуулж, мэдээ мэдээллээр хангаж ажилласан.Шалгалтад хамрагдсан нийт хүүхдийн цэцэрлэг болон сургуулиудад | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | илэрсэн зөрчлийг арилгуулах мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан ба давхардсан тоогоор нийт 217 зөрчил илрүүлэн 130 зөрчил буюу 59,9%-ийг газар дээр нь арилгуулсан.<br>Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр зөрчлийг арилгуулах 12 хугацаат албан шаардлага, үйл ажиллагааг түр зогсоох 4 акт үйлдэн ажилласан.<br>Сургууль, цэцэрлэгүүдэд хийсэн урьдчилан сэргийлэх хяналтаар илэрсэн зөрчил дутагдалыг арилгуулахаар газрын даргын албан бичгээр хугацаат 17 заалттай чиглэл хүргүүлж ажилласан. 5. Эрүүл мэндийн газрын 2023 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын ерөнхий байцаагчийн баталсан 10/00/32 тоот удирдамжийн дагуу “Зост-Өлгий” зуслангийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн. 10.6.7 кодтой хяналтын хуудас”-ны үнэлгээ 43% буюу “дунд” эрсдэлтэй үнэлэгдсэн, 42 зөрчил ирүүлэн 18 зөрчил буюу 42,8%-ийг газар дээр нь арилгуулсан ба Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр илэрч буй зөрчлийн гадна орчин, барилга байгууламжтай холбоотой зөрчил 7,1%, усан хангамж ариун цэврийн байгууламжтай холбоотой зөрчил 52,6%, амрах байрны эрүүл ахуй шаардлагтай холбоотой зөрчил 50%, хүүхдийн эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой зөрчил 46,1%, хоол үйлдвэрлэлд тавигдах шаардлагатай холбоотой зөрчил 41.1%, дотоод хяналттай холбоотой зөрчил 66%-ийг эзэлж байна. Зөрчил дутагдал арилгуулах 9 заалт бүхий албан шаардлага хүргүүлж ажиллалаа. Зуслангийн эрхлэгч, багш, тогооч, нярав болон холбогдох хүмүүсийг оролцуулан хяналт шалгалтын дүн, анхаарах асуудал, зуслангийн эрүүл ахуйн нөхцөл, хоол, хүнсний аюулгүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байдлыг хангах чиглэлээр сургалт зохион байгуулав. 6. Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/25 тоот “Ундны усны чанар аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт” хийх тухай удирдамжийн хүрээнд төвлөрсөн усан хангамжийн эх үүсвэрийн 2 гүний худаг, толгойн байгууламж, ус түгээх цэг зэрэг 8 обьект, Өлгий сумын ЗДТГ-ын харьяа болон “Суат” ХХК-ийн харьяа 21 гүний худаг, байгууллага аж ахуйн нэгж, айл өрхийн хувиараа гаргасан 4 гүний худаг болон 7 энгийн гар аргаар гаргасан худаг зэрэг нийт 40 объектэд  урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 156 зөрчил илрүүлж, 70 зөрчлийг газар дээр нь арилгуулж, улсын байцаагчийн 19 заалттай 3 хугацаат албан шаардлага хүргүүлж, 1 заалттай 1 дүгнэлт үйлдэж, 69 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Хяналт шалгалтын явцад ундны уснаас 80 сорьц авч, Стандарт хэмжил зүйн хэлтсийн Хими, нян судлалын лабораторид давхардсан тоогоор 1040 үзүүлэлтээр шинжилгээнд хамруулж, шинжилгээний дүнг Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах, Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандарттай харьцуулахад химийн шинжилгээгээр нийт ундны усны 2,5% нь кальци, 2,5% нь магни, 7,5% нь нитрат, 2,8% нь хатуулгийн  хэмжээ нь стандартад заасан зөвшөөрөгдөх хэмжээнээс их гарсан, нян судлалын шинжилгээгээр нийт ундны усны 27,5% нь гэдэсний савханцар буюу E.Coli, 2,5% нь гэдэсний бүлгийн эмгэг төрөгч нян буюу сальмонелла, 2,5%, нь нянгийн тооотой гарч, ундны усны холбогдох стандартын шаардлага хангаагүй үзүүлэлттэй гарсан байна.Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/24 тоот “Ахуйн болон урьдчилан цэвэрлэх байгууламжийн үйл | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагаа, цэвэрлэсэн бохир усанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу аймгийн НААҮ-ний Суат ХХК-ийн харъяа бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 17 зөрчил илрүүлж, улсын байцаагчийн 6 заалттай 1 хугацаат албан шаардлага хүргүүлж ажилласан. Хяналт шалгалтын явцад 2 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Бохир ус цэвэрлэх байгууламжийн орох, гарах хэсгийн бохир уснаас дээж авч аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторид химийн 9 үзүүлэлтээр шинжилгээнд хамруулан, шинжилгээний дүнг “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS 4943-2015” стандартад заасан үзүүлэлтүүдийн зөвшөөрөгдөх хэмжээнд харьцуулан үнэлгээ дүгнэлт өгсөн өгөхөд цэвэрлэгээний чанар 27.9%-тай гарсан байна.<br>Энэ нь сүүлийн жилүүдэд аймгийн төвд бүтээн байгуулалтын ажил их хийгдэх болсонтой холбоотой төвлөрсөн цэвэр, бохир усны шугамд холбогдох айл өрх, орон сууц, худалдаа, үйлдвэр, үйлчилгээний газрууд эрс нэмэгдэж, цэвэрлэх байгууламжийн хоногийн хүчин чадал хэтэрч ачаалал ихэссэнтэй холбоотой байна.<br>8. Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/26 тоот “Хот суурин газрын хөрсний бохирдлын түвшинд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу аймгийн төвийн суурьшлын бүсийн хөрсний бохирдлын түвшинг тодорхойлохоор 5 цэг тогтоож, GPS-ээр тогтоосон ццэгүүдийн координатыг тодорхойлж, координатжуулж ажилласан. Өлгий сумын 13 дугаар багийн нийтийн гудамж талбай, 4 дүгээр баг НААҮ-ний Суат | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ХХК-ийн харьяа төв цэвэрлэх байгууламжийн лагийн талбайн орчим, 9 дүгээр баг Нэгдсэн хогийн цэгийн ойролцоо газар, 13 дугаар баг үйлдвэрийн бүсийн нийтийн гудамж талбай, 11 дүгээр баг Хөгжмийн драмын театрын урьд нийтийн гудамж талбай зэрэг 5 цэгээс 5 хөрсний дээж авч аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн итгэмжлэгдсэн нян судлалын лабораторид шинжилгээнд хамруулж, стандартын шаардлага хангаж буй эсэхэд үнэлгээ, дүгнэлт хийж ажилласан.<br>Шинжилгээний дүнг “Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ MNS 3297:1991 стандартын үзүүлэлттэй харьцуулж дүгнэхэд: 5 сорьцын 1 сорьц буюу 20%-д гэдэсний савханцар, 1 сорьц буюу 20%-д клостридум перфрингес илэрч, гэдэсний бүлгийн эмгэг төрөгч буюу сальмонелла илрээгүй бөгөөд нийт сорьцын 2 сорьц буюу 40% нь бага бохирдолтой, 3 сорьц буюу 60% нь цэвэр гэсэн шинжилгээний дүнтэй гарсан байна.<br>9. 1.Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газраас ирүүлсэн удирдамжийн дагуу аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй 22 худалдааны газарт урьдчилан хяналт шалгалт хийсэн ба хүнсний худалдааны газруудад гарал үүслийн гэрчилгээ, шинжилгээний бичиггүй Бельги улсад үйлдвэрлэсэн “Cachet” нэрийн шоколад, Испани улсад үйлдвэрлэсэн 10 кг-аар савласан алмонд (буйлс-almond) самар худалдан борлуулсан зөрчил илрээгүй болно. Худалдааны газруудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | |
| 16.3 | Мах, махан бүтээгдэхүүн, өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэгчдэд үйл ажиллагаа явуулахаас өмнө урьдчилсан хяналт хийж | Батлагд сан төсвийн хүрээнд | 50 мах махан болон сүү, сүүн бүтээгдэхүү ний | 2 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нд хүсэлтээр | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын | Хүсэлт ирээгүй | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дүгнэлт гаргах | | үйлдвэрт урьдчилсан хяналт хийж үйлдвэрлэлийн үйл ажиллагааны талаарх улсын /ахлах/ байцаагчийн 49 дүгнэлт гаргасан. | урьдчилсан хяналт хийж, улсын байцаагчийн дүгнэлт гаргасан. | шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээний тоо нэмэгдэнэ. | | |
| 16.4 | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын барилга байгууламж барих газар олголт, зураг төсөл зохиох, ашиглалтад хүлээн авахад эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийх | Батлагдсан төсвийн хүрээнд | Эрүүл мэнд, сургалтын байгууллага, хүнсний болон нийтийн үйлчилгээний байгууллагуудын барилга байгууламжийг шинээр төлөвлөхөд норм дүрэмд нийцсэн эсэхт дүгнэлт гаргах. | Халдвар судлал, орчин, хүүхэд, хүнсний эрүүл ахуйн хяналтын чиглэлээр 30 аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлтээр барилгын зураг төсөлд эрүүл ахуйн урьдчилан сэргийлэх хяналт хийхэд холбогдох материал дутуу 2 зургийг буцааж, Эрүүл ахуйн тухай | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын шаардлагад нийцсэн үйлдвэрлэл, үйлчилгээний тоо нэмэгдэнэ. | Хүүхдийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр: 10-00-07 тоот удирдамжийн дагуу хүүхдийн эрүүл ахуйн чиглэлээр 3 ААН, 2 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн мөрөөр барилгын зураг төсөлд эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийж, 2 зураг төсөл хангасан, 1 зураг төсөлд өөрчлөлт оруулах дүгнэлт гаргаж ажилласан. Засаг даргын нийт 5 захирамжаар барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд орж 3 барилга, 7 боловсролын байгууллагын ариун цэврийн байгууламжид тавьж 16 дутагдлыг арилгуулахаар саналын хуудасд тусгаж үүрэг даалгавар өгч ажилласан ба биелэлт хангуулсан 3 барилгын ашиглалтад хүлээн авсан.<br>Орчны хяналтын чиглэлээр: Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр ирүүлсэн 24 барилга байгууламжийн зураг төсөлд эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийж, барилгажих газрын шаардлагыг хангаагүй, зураг төсөл боловсруулах даалгаврын дагуу бүрэн хийгдээгүй, холбогдох хавсралт материал нь дутуу зэрэг шаардлага хангаагүй 3 зураг төслийг газрын даргын албан тоотоор, холбогдох баримт бичиг нь дутуу 1 зураг төслийг газар дээр нь буцааж, шаардлага хангасан 20 зураг төсөлд улсын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хууль болон холбогдох хууль, норм, дүрэм журмын шаардлага хангасан 24, шаардлага хангаагүй 4 улсын байцаагчийн дүгнэлт, 2 зураг төсөлд өөрчлөлт оруулах дүгнэлт гаргаж ажилласан. Барилга байгууламж барих газрын байршлыг тогтоох урьдчилсан хяналтыг 3 объектэд хийсэн. 4 шинээр баригдсан барилгыг байнгын ашиглалтад хүлээж авах улсын комисст ажиллаж илэрсэн зөрчил | | байцаагчийн дүгнэлт гаргаж ажилласан. Урьдчилсан хяналтын явцад барилгын зураг төсөлд эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийлгүүлэхгүйгээр барилгын ажил эхэлсэн 1 зөрчлийг илрүүлж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж иргэнийг 250 нэгж буюу 250,000 төгрөгний шийтгэл ноогдуулж барагдуулсан.<br>Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 13 барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээж авах улсын комисст ажиллаж зөрчил арилгуулах саналаа бичиж, үүрэг даалгавар өгч 9 барилга байгууламжийг ашиглалтад хүлээж авч, 2 барилга байгууламжийн зураг төсөлд Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дах заалтын дагуу зураг төсөлд эрүүл ахуйн дүгнэлт гаргуулаагүй тул улсын комисст ажиллахаас татгалзаж, 2 барилга байгууламжид саналын хуудасаар үүрэг даалгавар өгч биелэлтээр хүлээн авахаар шийдвэрлэсэн байна.<br>Халдвар судлалын хяналтын чиглэлээр: Зооноз өвчин судлалын төвийн халаалт цэвэр, бохир усны холболтын барилгын зураг төслийг боловсруулсан “Рус-нур” ХХК-ийн боловсруулсан барилгын зураг төсөлд урьдчилан сэргийлэх хяналт хийж, улсын байцаагчийн 1 дүгнэлт гаргасан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дутагдлыг улсын комиссын тэмдэглэлд тусгуулж, зөрчлийг арилгуулах хугацаат үүрэг даалгавар өгч ажиллав. | | | |
| 16.5 | Удирдах дээд байгууллагын шийдвэр болон иргэн, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн өргөдөл гомдол, хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх: | Батлагдсан төсвийн хүрээнд | Өргөдөл гомдлыг хуулийн хүрээнд шуурхай барагдуулах | 50 өргөдөл гомдлын мөрөөр 97 обьектод төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн ба ирсэн өргөдөл гомдлын 48% нь орчны эрүүл ахуйн нөхцөл, 24% нь хүнсний чиглэлээр шинээр үйл ажиллагаа эрхлэхээр зөвлөгөө авах, 10% нь зураг хянуулах хүсэлт, 5% эмнэлгийн тусламж үйлчилгээний талаар, | Иргэдийн гомдлыг барагдуулсан байна. | 1. Өлгий сумын иргэдээс ирүүлсэн бохир усны цооног, халаалтын зуухны яндан, хог хаягдалтай холбоотой 7 өргөдөл, гоо сайхны салонтой холбоотой 1 өргөдлийг хүлээж авч, Эрүүл мэндийн газрын даргын баталсан 10-15/01, 10-15/04 тоот “Төлөвлөгөөт бус шалгалт хийх” тухай удирдамжийн дагуу хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтаар бохир усны цооногтой холбоотой 2 иргэнд улсын байцаагчийн хугацаат албан шаардлагаар үүрэг даалгавар өгч, биелэлтэд хяналт тавьж, 1 иргэнд улсын байцаагчийн дүгнэлт гаргаж ажилласан. Халаалтын зуухны яндантай холбоотой 1 иргэнд мөн хугацаат албан шаардлагаар үүрэг даалгавар өгч, биелэлтэд хяналт тавьж ажилласан. Хог хаягдалтай холбоотой 3 өргөдлийн дагуу илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулж, 1 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дах заалтын дагуу хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэж 50,0 төгрөгний торгуулийн арга хэмжээ авсан. Хяналт шалгалтын явцад 10 иргэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.<br>2. Мөн гоо сайхны газарт мэргэжлийн бус хүн орон байрны стандарт, эрүүл ахуйн шаардлага хангахгүй нөхцөлд батокс тариа, шивээсийн үйлчилгээ явуулж байгаа зөрчлийг илрүүлж, улсын ахлах байцаагчтай хамтарч тус үйл ажиллагааг хэсэгчлэн бүр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 13% нь бусад асуудал эзэлж байна. Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд барагдуулж өргөдөл гаргагчид албан бичгээр, дүгнэлтээр, зөвлөмж өөр хариу хүргүүлсэн байна. | | зогсоох арга хэмжээ авч, 2 хүнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.<br>3. Аймгийн Прокурорын газраас ирүүлсэн 01/158 тоот “Цагдаагийн газрын саатуулах байр, цайны газрын эрүүл ахуй, дулаан, чийглэг, зай талбайн хэмжээ, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдваргүйжүүлэх үйл ажиллагаа, хоолны илчлэг нь хуульд заасан хэмжээнд хүрч байгаа эсэхэд шалгалт хийж, дүгнэлт гаргаж өгөх” тухай албан бичгийн мөрөөр Эрүүл мэндийн газрын даргын баталсан 10-15/02 тоот “Төлөвлөгөөт бус шалгалт хийх” тухай удирдамжийн дагуу Цагдаагийн газрын саатуулах байр, цайны газарт Хүнсний эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчтай хамтарч саатуулах байрны эрүүл ахуйн нөхцөлд багажийн хэмжилттэй төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж улсын байцаагчийн хамтарсан дүгнэлт гаргаж хүргүүлсэн. Эрүүлжүүлэх, саатуулах байрны дарга болон эмч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.<br>4. Салбарын хяналтын газрын дарга, улсын ерөнхий байцаагчийн баталсан 10-00/43 дугаартай удирдамжийн дагуу 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр “Сорон минж” ХХК-ийн Өлгий сумын 11 дүгээр багт оршдог “Aiku's” арьс, гоо заслын эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамааруулж эмчилгээний чанарын болон халдвар судлалын хяналтын чиглэлээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, зөрчил арилгуулах зорилгоор хяналтын чиглэл тус бүрээр нийт 17 заалттай 2 албан шаардлагаар хугацаат үүрэг даалгавар өгсөн.<br>5. Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг Салбарын хяналтын газрын дарга, улсын ерөнхий байцаагчийн баталж ирүүлсэн 10-00/46 дугаартай удирдамжинд заасны дагуу 2 үе шаттайгаар зохион байгуулж явууллаа. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эмчилгээний чанарын хяналтын чиглэл Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.1, эм, биобэлдмэлийн чиглэл дээрх хуулийн 19.3.2-19.3.6, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын чиглэл 19.3.8-д заасан чиглэлээр олгосон эрүүл мэндийн байгууллага болон эм хангамжийн байгууллагуудын тусгай зөвшөөрлийн гэрчилгээг нэг файл үүсгэн pdf хэлбэрээр гаргаж, тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын нэгтгэл хүснэгтийн хамт заасан хугацаанд холбогдох улсын ахлах байцаагч нарт хүргүүлсэн.<br>6. АТГ-аас ирүүлсэн албан бичгийн мөрөөр 2017-2022 оны төрөх, мэс заслын тасагт нугасны мэдээ алдуулалтаар хагалгаанд орсон өвчтнүүдийн 4838 өвчний түүхэнд судалгаат хяналт хийж, зөрчил арилгуулахаар Нэгдсэн эмнэлгийн даргад 4 заалттай албан шаардлага үйлдэж биелэлтийг хангуулсан.<br>7. 2023 онд 151 албан бичиг, 28 өргөдөл гомдол хүлээн авч, үүнээс албан бичгээр хариу өгсөн-58, харьяаллын дагуу шилжүүлсэн-3, улсын байцаагчийн дүгнэлт гаргасан-19, бусад байдлаар шийдвэрлэсэн-24, хариугүй-41 байна.<br>8. Сургуулийн орчинд байрлалтай хүнсний дэлгүүрүүдэд “Хүүхдийн эрүүл мэндэд хортой хүнсний бүтээгдэхүүн худалдан борлуулж байна” гэх утга бүхий цахим орчинд байрлуулсан иргэдийн мэдээллийн мөрөөр аймгийн Прокурорын газар, Эрүүл мэндийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нарын баталсан удирдамжийн дагуу аймгийн төвийн сургуулийн орчинд байрлалтай 18 хүнсний худалдаа, үйлчилгээний газруудын үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, 75 зөрчил илрүүлж, 62 буюу 82,6%-ийг газар дээр нь арилгуулж, 4 газарт 18 заалттай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хугацаат албан шаардлага хүргүүлж, 8 хүнсний дэлгүүрээс 342000 төгрөгийн хаяг шошгын зөрчилтэй, 2441800 төгрөгийн хадгалах хугацаа нь дууссан хүнсний бүтээгдэхүүн хураан авч 8 газарт 10,000,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 61 хүнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.<br>9. Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 10-00/28 тоот удирдамжийн дагуу аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа нийт 23 хүнсний худалдааны газруудад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж, шалгалтад хамрагдсан тамхи, тамхин бүтээгдэхүүнийг худалдаалах газруудад хаяг шошгын зөрчилтэй, тамхийг ширхэглэн худалдаалсан, тамхины ил, далд сурталчилгаа явуулсан, урамшуулалт худалдаа, сугалаа зохион байгуулсан, 21 нас хүрээгүй иргэн худалдаалсан зэрэг зөрчил илрээгүй болно.<br>Хяналт шалгалтад хамрагдсан тамхи, тамхин бүтээгдэхүүнийг худалдаалах газрууд Өлгий сумын Засаг даргаас тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ авч, худалдан борлуулж байгаа боловч 22 худалдааны газарт ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрийн зайг тодорхойлсон зураглалыг сумын Засаг даргын Тамгын газраар баталгаажуулсан баримт гаргахгүйгээр Өлгий сумын Засаг даргаас тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээ олгосон, худалдааны газрууд нь тамхийг тусгайлсан лангуугаар худалдаалдаг боловч худалдааны байгууллагын кассын дэргэд байрлуулж худалдалсан, өдөр тутмын урсгал цэвэрлэгээ хангалтгүй зэрэг нийт 47 зөрчил илрүүлж, 25 зөрчил буюу 53%-ийг газар дээр нь арилгуулж, тамхи, тамхин | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүтээгдэхүүнийг худалдаалж буй 23 газарт улсын байцаагчийн 10-15-02/073/03 тоот 9 заалттай зөвлөмж өгч, 1 худалдааны газарт 4 заалттай хугацаат албан шаардлага хүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн Өлгий сумын Тамгын газарт тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосон иргэн, хуулийн этгээдүүдэд ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн болон дотуур байрнаас 500 метрээс дээш зайг тодорхойлсон зураглалыг сумын Засаг даргын Тамгын газраар баталгаажуулсан баримт гаргаж, 500 метрий дотор байрлалтай тамхи, тамхин бүтээгдэхүүнийг худалдаалж буй газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг цуцалж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр хугацаат албан бичиг хүргүүлж ажилласан. | |
| 16.6 | Гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх. | Батлагдсан төсвийн хүрээнд | Салбарын эрсдэлийг бууруулна. Албан шаардлагын биелэлтийг хангуулна. | 197 обьектод гүйцэтгэлийн хяналт хийгдэж, албан шаардлагын биелэлт-79,3%, зөвлөмжийн биелэлт-72%-тай байна. Гүйцэтгэлийн шалгалтаар 22 обьектын эрсдэл буурсан бөгөөд үүнтэй уялдаж | Төлөвлөгөөт бус шалгалтын гүйцэтгэлээр хууль сахин мөрдөлтийн хувь нэмэгдсэн, харин зөвлөн туслах үйлчилгээний гүйцэтгэлийн шалгалтаар хууль сахин мөрдөлтийн хувь буурсан байна. | Албан шаардлага өгсөн аж ахуйн нэгж байгууллагуудаас 60 обьектод гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн ба гүйцэтгэлийн хяналт шалгалтаар их-3, дунд-49, бага-8 эрсдэлтэй үнэлэгдсэн байна. Албан шаардлагын хэрэгжилт-58-85%-ийн биелэлттэй. Гүйцэтгэлийн хяналт шалгалтаар албан шаардлагын биелэлтийг хангуулж ажиллалаагүй Нэгдсэн эмнэлгийг Зөрчлийн тухай хуулийн дагуу 500000 төгрөгний шийтгэлийн арга хэмжээ авсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | эрсдэл үүсэх магадлал ын хувь 2-4,5%-иар буурсан байна. | | | |
| Стратеги төлөвлөгөөний зорилго 17. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ | | | | | | | |
| 17.1. | Хяналтын чиглэл бүрээр эрүүл мэнд, сургалтын байгууллага, хүнс болон нийтийн үйлчилгээний байгууллагуудад салбарын сургалт зохион байгуулах. | Батлагд сан төсвийн хүрээнд | Нийтдээ 240 аж ахуйн нэгж байгууллаг ын 2450 ажилтнууд ад зохион байгуулсан. 12 нэр төрлийн гарын авлага зөвлөмж өөр хангаж ажилласан. | Нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төв, сумын эрүүл мэндийн төвийн 23 эрүүл мэндийн байгуул лагын 30 чанарын баг, чанарын комис сын гишүү дэд “Эмнэлги йн тусламж ийн чанарыг сайжруу лахад анхаа рах нь” сэдэвт сургалт ыг зохион | Сургалтад холбогдох байгуулла га, аж ахуйн нэгж, ажилтан албан хаагчдыг бүрэн хамруулж зохион байгуулса н байна. Сургалтын үр дүнгийн үнэлгээг хийсэн байна. Аюулгүй хүнс үйлдвэр лэх, үйлчилгээ үзүүлэх нөхцөл, шаардлага хангах, эрх зүйн мэдлэг олгоход чиглүүлсэн байна. | 1.“Өдөр өнжүүлэх бүлэгт тавигдах шаардлага” сэдэвт ЭМЯ Салбарын хяналтын ерөнхий байцаагчийн баталсан хөтөлбөрийн дагуу “Өлгий сайхан гэрэл” өдөр өнжүүлэх бүлгийн багш, тогооч 2 хүнийг хамруулан онлайн сургалтанд хамрагдсан.<br>2.Аймгийн эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөнд оролцож, 45 эрүүл мэндийн байгууллагын нийт 130 эмнэлгийн мэргэилтнүүдэд эмчилгээний чанар, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтаар илэрч буй нийтлэг зөрчлүүд цаашид анхаарах асуудал сэдвээр мэдээлэл хийсэн.<br>3. ХӨСҮТ-өөс ирсэн ажлын хэсэгтэй хамтарсан “Халдварын сэргийлэлт, хяналт” сэдвээр НЭ-ийн тасаг нэгжүүдийн эрхлэгч, ахлах сувилагч нийт 26 хүнийг хамруулсан танхимын сургалт явуулсан.<br>4.ЭМГ-ын Халдварт өвчин хариуцсан мэргэжилтэнтэй хамтарч Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад халдварын сэргийлэлт, хяналтын чиглэлээр баримтлах тушаалуудаар хамтарсан цахим сургалтыг хийж сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүд нийт 35 хүн хамрагдсан.<br>5.Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газар болон аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Эрүүл мэндийн байгууллагуудад “Эмнэлгийн тусламжийн чанарыг сайжруулахад анхаарах нь” сэдэвт сургалт зохион байгуулах ажлын хүрээнд: Нэгдсэн эмнэлгийн-80, хувийн ортой эмнэлгийн- | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгуулж мэргэ жил арга зүйн зөвлөгөө өглөө. "Эрүүл мэндийн байгууллагуудад нийтлэг илэрч байгаа дутагдал, шалт гаан нөхцөл, арилгах арга зам” сэдвээр салбарын сургалтыг зохион байгуулж 28 эрүүл мэндийн байгууллагын 135 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамааруулж мэргэ жил арга зүйн зөвлөгөө | | 24, сумын эрүүл мэндийн төвийн -230 эмнэлгийн мэргэжилтнүүд зохион байгуулсан.<br>6. Хүнсний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр 3 удаагийн сургалтаар 46 байгууллага аж ахуйн нэгжийн 127 хүнийг сургалтанд хамааруулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | өгч ажиллас ан. Хоол үйлдвэр лэл үйлчигээ , худал дааны газарууд , хүнсний үйлдвэр, цехүүдэд “Эрүүл ахуйн болон үйлдвэр лэлийн зохистой дадлыг нэвтрүү лэх арга зүй” сэдэвт сургалты г 3 үе шаттай гаар зохион байгуулж , хүнсний гаралтай хордлого болон аливаа эрсдэл ээс урьдчил ан сэргий лэж ажиллах талаар | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч улсын байцаагч нарын хамтарсан 45 заалттай 3 улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлж, биелэлтийг хангуулсан. Сургалтанд нийт хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч 78 газрын 101 хүн хамрагдсан. | | | |
| 17.2. | Хяналт шалгалтын дүнгийн талаар болон хяналтын чиглэл бүрээр орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэл, сэрэмжлүүлэг, зөвлөмж өгөх. | Батлагдсан төсвийн хүрээнд | Хяналт шалгалтын ажиллагаа ил тод байна. Иргэдийг мэдээ, мэдээллээр хангана. | 2022 онд 5 хяналтын чиглэлээр орон нутгийн радиогоор-24 удаа, | Иргэд мэдээ, мэдээллээр хангагдана. | Тайлант хугацаанд хяналт шалгалтын явцтай холбоотой байгууллагын ФБ, фэйж хуудсанд 25 удаа, хяналт шалгалтын дүнгийн мэдээлэл, хүнсний болон орчны аюулгүй байдлыг хангуулах зорилгоор радиогоор -8 удаа, телевизээр 5 удаа сэрэмжлүүлэг, зөвлөмж өгөгдсөн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | телевизээр-30 удаа мэдээлэл, сэрэмжлүүлэг, зөвлөмж хүргүүлсэн. | | | |

Нийт 17 зорилго, 92 төрлийн арга хэмжээний биелэлт- 96,7%-тай байна.

Хянасан: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэсийн дарга Ш.Иманхан

Нэгтгэсэн: АШТҮХ мэргэжилтэн Ж.Нурбота